



GRAND DUCHY OF LUXEMBOURG
Ministry of Foreign Affairs

Directorate for Development Cooperation



Mongolia

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр

Орон: Монгол Улс

Төслийн баримт бичиг

Төслийн нэр:	“Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент зохицуулалтын чадавхийг сайжруулах нь”
НҮБХТХ-нд зорьж буй үр дүн:	Байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн эрсдэл, үр дагавар үндэсний болон орон нутгийн түвшинд буурна
Хэрэгжих улсын хувьд хүлээгдэж буй үр дүн:	Байгалийн баялагийн менежмент, эко-систем болон хүн амын эмзэг бүлгийн цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох байдал сайжирна
Төлөвлөсөн зорилт:	Үндэсний хэмжээнд уур амьсгалын болон гамшгийн эрсдлийн менежментийг зохицуулалт, харилцаа холбоо болон сүлжээний хувьд сайжруулна Нийгмийн эмзэг бүлэг, олон нийтийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон гамшгийн эрсдлийн бууруулах чадавхийг бэхжүүлнэ
Хэрэгжүүлэх түнш:	Шадар сайдын ажлын алба/Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар
Хариуцагч талууд:	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам болон Монгол Улсын Шинжлэх ухааны академи

Товч танилцуулга

Төслийн гол зорилго нь гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, харилцах зохицуулах арга механизмыг тогтвортой хэрэгжүүлэх замаар гамшгийн менежментийн төвлөрлийг багасгахад дэмжлэг үзүүлж, хот суурин газар, хөдөө орон нутгийн ядуу иргэдийн эмзэг байдлыг бууруулахад оршино. Төслийн хүрээнд хот суурин газар болон хөдөө орон нутгийн онцлогт тохирсон гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлж, орон нутгийн түвшинд гамшгийн менежментийн оновчтой арга механизмыг албан ёсоор бий болгон оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох замаар гамшгийн менежментийн чадавхийг бэхжүүлнэ. Бодлогын түвшинд гамшгийн менежментийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд уялдуулан нэгтгэх асуудлыг сайжруулахыг зорилго болгоно. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд дараах зорилтуудын хүрээнд хэрэгжинэ. Үүнд: 1) Бодлого, зохицуулалтаар үүрэг, хариуцлагыг тодорхой болгон гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийг сайжруулах; 2) Орон нутгийн гамшгийн удирдлагын механизмыг хот суурин газар, хөдөө орон нутгийн эмзэг байдлыг тооцсон дүрэм журам, чадавхитай болгох; 3) Орон нутагт тохирсон гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах механизмыг түгээн дэлгэрүүлэх зэрэг болно.

Хугацаа: 2012 – 2016 он Үр дүнд хүрэх гол чиглэл : Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхийг бэхжүүлэх Атлас дахь дугаар : Эхлэх хугацаа: 2013 оны 2 сарын 1 Дуусах хугацаа: 2016 оны 12 сарын 31 Хорооны хурал: 2012 оны 11 сарын 20 Менежментийн зохицуулалт: Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх	Шаардлагатай нийт хөрөнгө: 1.500.000 ам.доллар Хандивлагчдаас: 1.400.000 ам. доллар <ul style="list-style-type: none"> • Ердийн TRAC1 : 100,000 ам. доллар • Бусад: Люксембургийн Засгийн газрын буцалтгүй тусламж : 1,400,000 ам.доллар • Монгол Улсын Засгийн газар
---	---

Зөвшөөрсөн /Засгийн газар/:

Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва /огноо

Зөвшөөрсөн /Засгийн газар/:

ОБЕГ-ын дарга Т.Дуламдорж /огноо

Зөвшөөрсөн /НҮБХХ/

Сезин Синаноглу, Суурин төлөөлөгч /огноо

Товчилсон үгс

ADB	Азийн хөгжлийн банк	АХБ
BCPR	НҮБХХ-ийн хямралаас сэргийлэх, сэргээх товчоо	ХССТ
CBDMU	Олон нийтэд түшиглэсэн гамшгийн менежмент хариуцсан нэгж	ОНГМН
CBO	Олон нийтэд түшиглэсэн байгууллага	ҮНТБ
CCA	Улс орны нийтлэг үнэлгээ	УНУ
DM	Гамшгийн менежмент	ГМ
DMP	Гамшгийн менежментийн төлөвлөгөө	ГМТ
DPM	Шадар сайд	ШС
DRM	Гамшгийн эрсдлийн менежмент	ГЭМ
DRR	Гамшгийн эрсдлийг бууруулах	ГЭБ
DRRPC	Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөл	ГЭБТХАЗ
EMD	Аймгийн онцгой байдлын хэлтэс	АОБХ
GIZ	Германы олон улсын хамтын ажиллагааны агентлаг	ГОУХА
FAO	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага	ХХААБ
HFA	Хёогогийн үйл ажиллагааны хүрээ (2005-2015)	ХҮАХ
ICT	Мэдээлэл, харилцаа холбооны технологи	МХХТ
IFAD	Хөдөө аж ахуй, хөгжлийн олон улсын сан	ХААХОУС
LC	Орон нутгийн зохицуулагч	ОНЗ
MDGs	Мянганы хөгжлийн зорилтууд	МХЗ
MoFALI	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	ҮХААЯ
MNABET	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	БОНХЯ
MES	Боловсрол, шинжлэх ухааны яам	БШУЯ
NCDB	Улсын иргэний хамгаалалтын газар	УИХГ
NFA	Үндэсний үйл ажиллагааны хүрээ 2006-2015	ҮҮАХ
NEMA	Онцгой байдлын ерөнхий газар	ОБЕГ
NIM	Үндэсний гүйцэтгэлийн загвар	ҮГЗ
NGO	Төрийн бус байгууллага	ТББ
NPD	Төслийн үндэсний захирал	ТҮЗ
NPC	Төслийн үндэсний зохицуулагч	ТҮЗ
Nukhurlul	Малчдын бүлэг	МБ
PB	Төслийн удирдах зөвлөл	ТУЗ
PIU	Төсөл хэрэгжүүлэх нэгж	ТХН
RMMAP	Нөөц материал дайчлан бүрдүүлэх төлөвлөгөө	НМДТ
PPE	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл	НБХХ
PRA	Гамшигтай тэмцэх бэлтгэлийн үнэлгээ	ГТБТ
TOR	Ажлын удирамж	АУ
TPR	Гурван талын уузалт (Монгол улсын засгийн газар, Люксембургийн засгийн газар, НҮБХХ)	ГТУ
UNCT	НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар	НҮБСТГ
UNDAC	НҮБ-ын гамшгийн үнэлгээ, зохицуулалт	НҮБГҮЗ
UNDAF	НҮБ-ын хөгжлийн тусламжийн хүрээ	НҮБХТХ
UNDP	НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр	НҮБХХ
UNISDR	НҮБ-ын гамшгийг бууруулах олон улсын стратеги	ГБОУС
UNOCHA	НҮБ-ын хүмүүнлэгийн асуудлын зохицуулалтын алба	НҮБХЗА
UNTG	НҮБ-ын тусгай зорилтот бүлэг	НҮБТЗБ
USAID	АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг	ОУХА
WB	Дэлхийн банк	ДБ

Нэгдүгээр хэсэг. Нөхцөл байдал

1.1 Монгол улс дахь гамшгийн эрсдлийн байдал

Хэдийгээр Монгол улс нь хүн амын нягтшилаараа дэлхийд хойгуур жагсдаг ч олон төрлийн аюулд эмзэг байна. Удаан үргэлжлэх хүйтэн өвөл, жилд унах хур тунадасын хэмжээ бага төдийгүй зундаа гантай байдаг зэрэг нь Монгол улсыг хамгийн хатуу ширүүн уур амьсгалтай орнуудын тоонд оруулж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ган, зуд их гарч хөдөөгийн хүн амын амьжиргаанд ихээхэн нөлөөлснөөс гадна хурдацтай өсөн нэмэгдэж буй хотын иргэд гал, үер ус, газар хөдлөлт болон химийн хорт бодис алдагдах гэх мэт технологийн аюулд өртөх эрсдэлд амьдарч байна. Хурдацтай хөгжиж буй уул уурхайн салбар нь тус улсын байгаль орчинг төдийгүй хүн амынх нь амь нас, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол улсын цаг уурын эрс тэс үзэгдэл нэмэгдэж, эмзэг экосистемийг улам бүр доройтуулж болзошгүй байгаа нь байдлыг илүү хурцатгаж байна.

Зуд/Ган гачиг: Өвлийн улиралд тохиолддог хамгийн ноцтой аюулын нэг нь зуд юм. Энэ нь гэнэт эсвэл удаан хугацаагаар их хэмжээний цас орох, цаг агаар хэт хүйтрэх, хүчтэй шуурганы улмаас малын бэлчээр сүйдэх зэрэг хүчин зүйлээс гол төлөв үүддэг удаан үргэлжилдэг, нарийн төвөгтэй үзэгдэл юм. Зудын үед олон тооны мал өлсөх, ядрах, эсвэл хөлдсөний улмаас үрэгддэг учир түүнийг “малын өлсгөлөн” гэж ойлгож болно. Малчин өрхийн амьжиргаа малаасаа ихээхэн хамааралтай байдаг учир зуданд нэрвэгдсэн нутгийн эдийн засаг, иргэдийнх нь амьжиргаа эрсдэлд ордог. 1999-2001 онд Монгол улсад анх удаа дараалласан гурван жил ган, зуд болсны улмаас жил бүр 3 сая толгой малаа алдаж байсан. Мөн 2009-2010 онд болсон зудын улмаас 10 гаруй сая толгой мал буюу нийт малынхаа 22%-ийг алдсан. Уур амьсгалын өөрчлөлтийн загварын прогнозоор Монгол улсад цаашдаа зуд болон бусад цаг агаарын эрс тэс үзэгдлүүд улам бүр нэмэгдэнэ гэж тооцоолсон байна.

Газар хөдлөлт: Монгол улс нь газар хөдлөлтийн идэвхитэй бүсэд оршдог. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Рихтерийн шаталбараар 6 магнитудын хүчтэй 40 гаруй газар хөдлөлт болсон гэж тэмдэглэгдсэн байна. Харин 8-аас дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 20-р зуунд нийт 4 удаа болсон байна. Саяхан бусад орнуудад болсон гамшигт нөлөө бүхий газар хөдлөлтүүдийн дараа Монгол улсын засгийн газраас болзошгүй газар хөдлөлтийн аюулд бэлдэх арга хэмжээ авч эхлээд байна. Нийслэл хотын барилга байгууламжийн 70 гаруй хувь нь газар хөдлөлтөд тэсвэргүй гэж гарсан ба эдгээрт эмнэлэг, цахилгаан станцууд гэх мэт чухал барилга, дэд бүтцүүд багтаж байна. Үүнээс гадна хотын оршин суугчид газар хөдлөлтөд урьдаас бэлдэх, газар хөдлөлтийн үед амиа аврах шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар наад захын мэдлэггүй байна.

Ой, хээрийн түймэр: Монгол улсад жил бүр маш олон ой, хээрийн түймэр гардаг. Тус улсын нийт газар нутгийн 55,6 орчим хувь нь ой, хээрийн түймэрт өртөмхий бүст багтдаг. Монголын ойн экосистемийг гал түймэр гарах эрсдэл өндөртэй гэж үздэг ч хүний үйл ажиллагаанаас үүдэн гарч олон хүний аминд хүрсэн гал түймэр олон байна. Мэргэжлийн гал сөнөөгчдийн хамгаалалтын хувцас, хэрэглэл дутмаг байгаа нь олон хүний амь нас үрэгдэхэд хүргэж байна. 2012 оны 5-р сард Дорнод аймагт гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах ажиллагааны үеэр 4 гал сөнөөгч амь насаа алдсан. Хүний амь нас, эд баялаг, улсынхаа ойн нөөцийг авран хамгаалах нь Монгол улсын гамшгийн эрсдлийн менежментийн үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн юм. Ойн түймэр нь биотикийн буюу шим ертөнцийн аюулаас ч илүүтэй ой модыг сүйтгэдэг.

Үер: Хот суурин газрын гэнэтийн үер нь Монгол улсын гамшгийн эрсдлийн нэмэгдүүлэхэд нөлөөлж буй гол аюулын нэг юм. Хот суурин нэн ялангуяа нийслэл Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн их байгаагаас эрсдэл нэмэгдэж, хотод суурьших газар улам бүр хумигдан хүмүүс Дархан цаазат Богд хаан уулын зарим хэсэг, Туул голын хөндийд хүртэл суурьшиж эхлээд байна. Хөдөөнөөс шилжин суурьших үйл явц идэвхижиж байгаатай холбоотой ялангуяа гэр хороололд төлөвлөлт, зохицуулалтгүй суурьших явдал нэмэгдсээр байна. Хотын захын гэр хорооллын айлууд ихэвчлэн үерийн аюултай газар ямар ч хамгаалалтгүй амьдарч байна. Улаанбаатар хотын үерийн хамгаалалттай дэд бүтцийн ихэнхи нь 1940-өөд оноос хойш болсон хамгийн хүчтэй үер болох 1966 оны үерийн дараа байгуулагдсан. Үерийн хамгаалалтын засвар үйлчилгээг зохих түвшинд хийхгүй явж ирснээс шалтгаалан Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын байгууламж аадар бороо эсвэл хаврын шар усны үерийг даах боломжгүй болсон байна. Жил ирэх бүр гэнэтийн аадар бороо болон учруулах хохирлын хэмжээ нь нэмэгдсээр байна. Жишээ нь 2009 оны 7 дугаар сарын 17, 21-нд орсон хүчтэй аадар борооны \30-60 минутын хугацаанд 17-51.6 мм\ улмаас 2000 өрхийг нүүлгэн шилжүүлж, 2.7 тэрбум төгрөгийн \1.93 сая ам. доллар\ хохирол учирсан байна. Хэрэв таамаглаж байгаачлан хур тунадасны хэмжээнд өөрчлөлт гарвал хүн ам тэр дундаа ширгэсэн голын ойролцоо амьдарч буй хүмүүст шууд нөлөөлнө.

Цас ба шороон шуурга: Хүчтэй цасан шуурга нь Монголд тохиолдож буй бүх гамшгийн аюулаас хамгийн эрсдэлтэй нь бөгөөд ихэвчлэн нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй малчид цасан шуурганд малтайгаа төөрөх эсвэл шуурганд уруудсан малаа эрж яваад төөрөх хэлбэрээр өртөж байна. 2011 оны 1-р сард болсон цасан шуурганд 12 хүн, 2011 оны 4-р сарын цасан шуурганд 11 хүн осолдож амь насаа алдсан байна. Хүчтэй шуурганы үед мод хугарах, цахилгаан ба телефон утасны шугам тасрах, байшин барилга, гэр нурах зэрэг үзэгдэл гардаг. Монголд хүчтэй шороон шуурганы 60 орчим хувь нь хавар тохиолдож байна. Шороон шуурга нь дунджаар 3.1-6.0 цаг үргэлжлэх ба хурд нь 6-20 метр\секунд байдаг. Хүчтэй шороон ба элсэн шуурга нь агаарын чанар, үзэгдэх орчинд нөлөөлж байдаг. Монголын говь болон Хятадын хойд хэсгээс гарч буй хуурай хөрсний нарийн тоосонцор нь зүүн тийш салхиар хөөгдөн Солонгос, Япон, Оросын алс дорнод, цаашилбал зарим үед АНУ-ын алс дорнод дахь агаарын чанарт хүртэл нөлөөлж байна.

Малын халдварт өвчин, түүний тархалт: 50 орчим сая толгой малтай /2012 оны байдлаар/ Монгол улсын хувьд вирус болон бактерийн гаралтай малын гоц халдварт өвчин нь эдийн засгийн хувьд ихээхэн хохирол учруулдаг. Хөдөөний малчин өрхүүд түүхий малын махаа өөрсдөө боловсруулдаг учир малын халдварт өвчинд нэрвэгдэж, эрүүл мэндээрээ хохирох явдал их байна. Аюул учруулж буй нийтлэг өвчинд шүлхий, галзуу, адуу ба тэмээний томуу, гахай, шувууны томуу болон боом өвчин орж байна. Шүлхий нэлээд ойр давтамжтай гарч, хонь, ямаа, үхэр, тэмээ зэрэг салаа туурайтай амьтан олноор нэрвэгдэж байна. Энэ өвчин нь Монголын цагаан зээр болон бусад зэрлэг өвсөн тэжээлтэнд хүртэл халдварлан тархдаг ба нялх малд туйлын эрсдэлтэй учир үүнтэй тэмцэх явдал чухал сорилт болоод байна. Иймээс өргөн хүрээнд хяналт тавьж, урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үйлдвэрийн осол ба химийн бодис алдагдах: Ерөнхийд нь авч үзвэл Монгол улсын химийн бодисын менежментэд ахиц дэвшил гарч байгаа ч энэ чиглэлийн мэргэжлийн байгууллага, хүн амын мэдлэг, туршлага хязгаарлагдмал байгаатай холбогдон бэрхшээл гарсаар байна. 2007 онд Дархан-Уул аймгийн Хонгор сумын алтны уурхайд химийн хорт бодис алдагдсан явдал Монгол улсын

химийн хорт бодис алдагдах аюултай тэмцэх бэлтгэл туйлын хангалтгүй байсныг харуулсан. Энэ чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах хэрэгтэй. Монгол улсад химийн хорт бодис алдагдаж хүний эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд учруулсан хохирлын талаар хийсэн судалгааны тайлан мэдээ цөөхөн байдаг төдийгүй олон нийтэд сайн танигдаагүй байна. Тиймээс химийн хорт бодисын нөлөө буюу хордогдох үеийн шинж тэмдэг, түүний байгаль орчинд учруулах нөхөж болшгүй хохирлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийж гарын авлага, удирдамжийг боловсруулан, мэргэжлийн байгууллага болон олон нийтэд таниулан түгээх нь зүйтэй.

Хүснэгт 1. Хот, хөдөөгийн гамшгийн эрсдлийн ерөнхий байдал

Гол гамшгийн эрсдлүүд	Хот суурин газарт		Хөдөө орон нутагт	
	нөлөө	давтамж	нөлөө	давтамж
Зуд\ган	бага	дунд	их	дунд
Газар хөдлөлт	их	бага	бага	бага
Ой, хээрийн түймэр	бага	бага	их	дунд
Объектын түймэр	дунд	их	дунд	бага
Үер	дунд	их	дунд	дунд
Салхи/цасан шуурга	бага	дунд	их	дунд
Малын халдварт өвчин	бага	дунд	дунд	дунд
Химийн бодисын алдагдалт	дунд	дунд	бага	бага
Үйлдвэрийн осол	дунд	дунд	бага	дунд

1.2. Монгол Улсын гамшгийн эрсдлийг бууруулах арга механизмд гарсан дэвшил

НҮБХХ болон хөгжлийн бусад түншүүдийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын засгийн газар гамшгийн эрсдлийн менежментийн чиглэлд нэлээд амжилтад хүрсэн. НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэд хэдэн үе шаттай хэрэгжүүлсэн гамшгийн менежментийн төсөл нь Монголын гамшгийн эрсдлийн менежментийн бүтэц зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Чадавхийг бэхжүүлэхэд үзүүлж буй дэмжлэг нь 2005-2015 онд хэрэгжүүлэх ХҮАХ/Хёогогийн үйл ажиллагааны хүрээ/-нд заасан үзэл санаатай нийцэж байна.

Төслийн нэгдүгээр шатны үр дүнд Гамшгаас хамгаалах тухай хуулийг боловсруулан батлуулсан ба Иргэний хамгаалалт, Улсын нөөц болон Гал түймэртэй тэмцэх газар гэсэн гурван бие даасан байгууллагыг нэгтгэн Онцгой байдлын ерөнхий газрыг \ОБЕГ\ байгуулсан. Төслийн хоёрдугаар үе шатанд гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө болон Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд \ХҮАХ\ суурилсан Үндэсний үйл ажиллагааны хүрээг \ҮҮАХ\ боловсруулан гаргасан. Мөн ОБЕГ, түүний орон нутаг дахь 30 салбарын чадавхийг бэхжүүлэх замаар Гамшгаас хамгаалах хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Олон нийтэд тулгуурласан гамшгийн менежментийн системийг туршилтаар хэрэгжүүлсэн ба дөрвөн аймгийн найман суманд Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэлийн зөвлөлийг \ГЭБТЗ\ байгуулсан.

Төслийн гуравдугаар үе шат нь өмнөх шатуудынхаа ажлын үр дүн, амжилтыг бататгасан. Төслийн хугацаа дуусах үед ОБЕГ-ын онцгой байдлын үед авах арга хэмжээ бүх шатандаа мэдэгдэхүйц сайжирсан байсан. Сургалтыг системтэй тогтмол явуулснаар байгууллагын хүний нөөцийн чадавхи бэхжсэн. Мөн байгууллагын үйл ажиллагааны, ялангуяа эрэн хайх болон аврах ажиллагааны чадавхи сайжирч, хувийн хамгаалалтын багаж хэрэгсэл болон химийн аюултай бодисын онцгой байдлын үед хэрэглэх иж бүрдэл, гал унтраах болон аврах багаж хэрэгслээр хангагдсан. ОБЕГ-ын материаллаг бааз суурийг олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор худалдан авалтын шинэ төлөвлөгөөг боловсруулсан. Бодлогын түвшинд гарсан томоохон амжилт бол “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого” \ГХТББ\ болон “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг \ГХЧБҮХ\ эцэслэн боловсруулж батлуулсан явдал юм.

Орон нутгийн түвшинд **10 сум, 2 дүүрэгт** 593 айл өрх буюу 2118 хүнийг хамарсан **55 хэсгийг** байгуулсан. Гамшгийн эрсдлийн менежментийн гол арга ажиллагааг сайтар ойлгосон малчдын, өөртөө болон нөхөртөө туслах бүлгийн гишүүд нь гамшгаас хамгаалах ажилд хамтран ажиллаж байна. Мөн тэд орон нутгийн түвшинд нэн ялангуяа ГЭБ түншлэлийн зөвлөл байгуулагдсан газруудын шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нутгийн иргэд өвөлжөөгөө сэргээн засаж, мөн тоног төхөөрөмж авч, сургалтад хамрагдан үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүндээ нэмүү өртөг шингээх, хадлан, өвс тэжээлийн агуулах барих зэрэг арга хэмжээнүүдийг авах замаар амьжиргаагаа дэмжин болзошгүй гамшигтай тэмцэх чадавхиа ихээхэн нэмэгдүүлсэн байна.

Гамшгийн менежментийн мэдээллийн систем бий болгох болон гамшгийн талаарх хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд нэлээд хүчин чармайлт гаргасан. Явуулын гэр мэдээллийн төвүүдийг байгуулснаар малчид, нутгийн иргэд орон нутгийнхаа талаар гамшгийн холбогдолтой мэдээлэл авах, мэдлэг мэдээллээ хоорондоо солилцох боломж нээгдсэн. Явуулын гэр мэдээллийн төвүүдийг бүх зорилтот газруудад ажиллуулсан ба тухайн орон нутгийн иргэдийн 30 орчим хувь нь тогтмол ирж мэдээлэл авч байна. Гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгийн менежмент болон уур амьсгалын талаар янз бүрийн гарын авлага бэлтгэн Монгол улсын бүх аймагт тарааснаар орон нутгийн иргэд эрсдэл ба түүнтэй тэмцэх арга хэмжээнүүдийн талаар илүү сайн ойлголттой болсон.

Төслийн хэрэгжилтийн тухай эцсийн үнэлгээнд “Гамшгийн эрсдлийн менежментийн харилцан уялдаатай ийм олон үйл ажиллагааг туршин ингэж хангалттай амжилтад хүрсэн орон дэлхийд цөөн байдаг гэж үнэлсэн ба хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаас нь дурьдвал: гамшгийн эрсдлээс хамгаалах ба уур амьсгалын эрсдлийн менежментийн салбар хоорондын бодлогыг шинээр боловсруулсан; ОБЕГ-ыг бие даасан төрийн, мэргэжлийн байгууллага болгосон; сум, хороо болон хот, хөдөө орон нутгийн түвшинд шинэ гамшгийн эрсдлийн менежментийн тогтолцоог бэхжүүлж, улмаар үндэсний системтэй холбон цар хүрээг нь өргөжүүлсэн; гамшгийн эрсдлийн менежмент болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой холбоотой олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх стратегийг хөгжүүлсэн”.

1.3 Олон улсын бодлогын хүрээ

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн ертөнцөд үзүүлэх гамшгийн нөлөө нэмэгдэхийн хирээр гамшиг ба эдийн засгийн өсөлтийн уялдаа холбоо нь хөгжлийн болон хүмүүнлэгийн бодлогын гол тулгуур асуудал болж байна. Энэ асуудлаар сүүлийн хорь гаруй жил судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр

2005 онд дэлхийн 168 орон 2005-2015 онд хэрэгжүүлэх “Хөогийн үйл ажиллагааны хүрээ: (шаардлагатай нөөцөөр хангаж, бүтэц зохион байгуулалтын болон эрх зүйн зохих бүтцийг бий болгох замаар) улс үндэстэн, орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхийг \ХҮАХ\ бий болгох нь” хэмээх баримт бичгийг боловсруулж, даган мөрдөх үүрэг амлалт авсан; ХҮАХ нь улс орноо гамшгийн аюулгүй болгох чиглэлд урт хугацааны, тогтвортой үүрэг амлалт авч хэрэгжүүлэхэд улс орнуудыг уриалан, зохих удирдамжаар хангасан. Иймээс энэхүү баримт бичиг нь улс орнуудад хөгжлийн ололт амжилтаа хадгалан хамгаалах боломж олгохын зэрэгцээ гамшгийн эрсдэл ба 2015 онд хэрэгжүүлж дуусах Мянганы хөгжлийн зорилтуудын \МХЗ\ ололт амжилтуудыг холбосон гол гүүр болж байна.

Бүх хөгжлийн салбарууд гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг чухалчлан үзэж, үйл ажиллагаандаа уялдуулан тусгах нь улс үндэстэн, олон нийтийг гамшигтай тэмцэх чадавхитай болгоход чухал үүрэгтэй гэж ХҮАХ-нд үзсэн байна. Салбар бүрийн хувьд хамгийн чухлаар тавигдаж байгаа асуудал бол засгийн газар, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм

Хайрцаг 1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Монгол улсын их хурал
Тогтоол №22, 2011 оны 5-р сар

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, үйл ажиллагааны бүтээмжийг нь нэмэгдүүлэх, гамшигтай тэмцэх чадавхи, бэлэн байдлыг дээшлүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг дараах стратегийн зорилтуудаар хэрэгжүүлнэ:

2.2.1. Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийг оролцуулах, үйл ажиллагааны бүтээмжийг нь дээшлүүлэх;

2.2.2 Байгалийн, хүний хүчин зүйлийн болон техникийн үүдэлтэй аюул ослуудын эрсдлийн үнэлгээг төрөл тус бүрээр нь гаргаж, үндэсний хэмжээнд гамшгийн эмзэг байдлыг бууруулах компанит ажил зохион байгуулах;

2.2.3 Засгийн газар болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн эрсдлийн даатгалыг сайжруулах, гамшгийн үед үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийн асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн орчинг тодорхой болгох

2.2.4 Аюулт үзэгдэл, болзошгүй гамшиг, түүнийг урьдчилан мэдэх болон анхааруулгын мэдээлэл түгээх талаарх судалгааны ажилд орчин үеийн арга барил, техник технологийг ашиглах, эрт зарлан мэдээлэх системийг сайжруулах

2.2.5 Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд шаардлагатай хүн хүчний болон техникийн чадавхийг бэхжүүлэх

/сайн дурынхан ба олон нийтэд тулгуурласан байгууллагуудыг оролцуулан/, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн сектороос өргөн хүрээтэй сонирхогч талуудыг татан оролцуулах явдал юм.

1.4 Гамшгийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого

2011 оны 3 дугаар сард Монгол улсын Парламентаас баталсан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого” \ГХТББ\ болон “Гамшгаас

хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний Хөтөлбөр” \ГХЧБҮХ\ -т Хөёогийн үйл ажиллагааны хүрээний \ХҮАХ\ гамшгийн эрсдлийг бууруулахтай холбоотой асуудлууд болон МХЗ-д суурилсан Монгол улсын үндэсний хөгжлийн цогц стратегийн \ҮХЦС\ зорилтуудыг тусгасан. Ирэх жилүүдэд тус улсын янз бүрийн гамшгийн хор уршгийг арилгах, зохих бэлтгэлтэй байх чадавхийг бэхжүүлэх зорилгоор олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Энэ хүрээнд авч хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээнүүдэд **гамшгаас хамгаалах үйл явцад оролцогч бүх талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж оролцооны хүрээг нь өргөтгөх, улсын болон хувийн хэвшлийн зохион байгуулалтын бүтцийг сайжруулан хөгжүүлэх, эрт зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэх дохионы системийг сайжруулах** асуудал орж байна. \Хайрцаг 1\

1.5 Гамшгийн менежментэд тулгарч буй гол бэрхшээлүүд

1.5.1 Томоохон хэмжээний гамшгийн зохицуулалт сул байна

2009-2010 онд болсон зудын гамшгийн сэргээн босгох үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн түншүүд Монгол улсын гамшгийн менежментийн төлөвлөлт, зохицуулалтын үйл явцыг сул гэж дүгнэсэн. **Монгол улсад төрийн болон орон нутгийн удирдах байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж, шат шатны засаг захиргааны гүйцэтгэх үүргийг ялган заагласан нэгдсэн тогтолцоо байхгүй, мөн чадавхи, нөөцийн хувьд дутагдалтай** байсан зэрэг хүчин зүйлс ингэж дүгнэхэд нөлөөлсөн байна. Цаашилбал зудын хор уршгийг арилгах арга хэмжээ цагаа олохгүй, зохион байгуулалт муутай явагддаг, ямар хэлбэрийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх нь тодорхойгүй, макро ба микро аль ч түвшинд байгаа нөөц бололцоо нь яаралтай тусламж шаардлагатай байгаа газраа очдоггүй, нөөцийн хуваарилалтын талаарх шийдвэр нь тодорхой хэмжээнд улс төрийн нөлөөлөлд автдаг зэрэг асуудлууд ажиглагдсан байна. Мөн төрийн байгууллагууд ба хөгжлийн түншүүдийн үйл ажиллагааны ил тод байдал, хоорондоо мэдээлэл солилцох байдал дутмаг байгаа нь ноцтой сөрөг нөлөөллийг бууруулах боломжийг алдахад хүргэдэг гэж үзсэн байна.

Томоохон хэмжээний гамшиг гарсан үед салбар хоорондын үйл ажиллагааг зохицуулах платформ байхгүй байна. НҮБХХ-өөс гаргасан 2010 оны Монголын хөгжлийн үр дүнгийн үнэлгээний тайланд НҮБХХ-ийн үйл ажиллагаа бодлогын түвшинд нөлөөлж, Онцгой байдлын ерөнхий газрын чадавхийг бэхжүүлэх, иргэдийн эмзэг байдлыг бууруулахад тулгарч байсан бэрхшээлүүдийг арилгахад тус дөхөм болсон тухай дурьдсан байна. Үүнээс гадна, **гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх болон гамшигтай үр дүнтэй тэмцэхэд шаардлагатай холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад анхаарч ажиллахыг санал болгосон.**

1.5.2 Орон нутгийн түвшинд гамшгийн менежментийн чадавхи хязгаарлагдмал байна.

ОБЕГ нь сумын түвшинд хүрч ажиллахгүй байгаа ба зөвхөн гамшгийн үед ажиллах гамшгийн менежментийн байнгын бус ажиллагаатай бүлэг байна. Ерөнхийдөө орон нутгийн гамшгийн менежментийн үйл ажиллагаа нь байнгын бус, цөөн тооны хандивлагчдаас ихээхэн хамааралтай байна. НҮБХХ-өөс гадна Улаан загалмай, Дэлхийн зөн гэх мэт олон улсын төрийн бус байгууллагууд бас олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд оролцож байна. ОБЕГ-ын аймаг, дүүргийн салбарууд бас эдгээр арга хэмжээнд оролцож байгаа ч, оролцоо нь нэр төдий байна. ОБЕГ үйл ажиллагаа нь ямар

газар зүйн байршлыг хамарч, орон нутгийн тэр дундаа сум, малчин айл өрхийн түвшинд ямар нөөц, чадавхитай байгаагаа тодорхой мэдэхгүй байна.

2011 оны Гамшгийн менежментийн хөтөлбөрийн эцсийн үнэлгээний тайланд **“хэдийгээр Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөлүүд, Малчдын бүлгүүд, өөртөө болон нөхөртөө туслах бүлгүүд байгуулагдаж, гамшгийн эрсдлийн менежментийн суурь мэдлэг, ур чадварыг эзэмшин, зарим нэг тоног төхөөрөмжтэй болсон ч орон нутгийн түвшинд ОБЕГ-ын төлөөлөл байхгүй байгааг”** цохон тэмдэглэсэн. Энэ нь сумын түвшинд **орон нутгийн өөртөө туслах бүлгүүдийн гүйцэтгэх** үүрэг болон түүнд ОБЕГ-аас ямар дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй нь тодорхой биш байгаатай холбоотой. Гэхдээ орон нутгийн сайн дурын-бүлгүүд албан ёсоор биш ч ОБЕГ-ын анхан шатны эрсдлийн менежментийн “нүд, гар, хөл” нь болж, гамшигтай бие даан тэмцэх замаар ОБЕГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

ОБЕГ нь одоогийн бүтэц, ажилтнууд, төсвийн хүрээнд орон нутгийн түвшинд хүчтэй үйл ажиллагаа явуулах боломжгүй байна. Эдгээр асуудлыг зөвхөн орон нутгийн чадавхийг бэхжүүлэх замаар бүрэн шийдэж чадахгүй. Бодит байдалд ГЭБТЗ, МБ, ӨТБ¹-ийн үйл ажиллагаа хааяа нэг хийдэг уулзалт, хурлаар хязгаарлагдаж байгаа нь энэ механизмыг тогтворжуулах албан ёсны зохицуулалт үгүйлэгдэж байгааг харуулж байна. Мөн ГХЧБҮХ-д заасан стратегийн зорилтуудыг нэн яаралтай хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Орон нутгийн захиргаа нь эрх зүйн хувьд гамшгийн эрсдлийг бууруулахад зориулан төсөв хуваарилах үүрэггүй учир гамшгийн үед зарцуулах тусгай төсөв байдаггүй. Улсын төсвөөс аймгуудад онцгой байдлын зориулалтаар хуваарилж байгаа хөрөнгө маш бага байдаг. Хамгаалалтын болон аврагч, гал сөнөөгчдийн багаж хэрэгсэл хангалтгүй байгаагийн улмаас аврах ажиллагааны үед аврах боломжтой хүний амь нас эрсдэх эрсдлийг нэмэгдүүлж байна. Сайн дурынхныг дайчлан ажиллуулах боломж их байгаа ч, тэдний дэмжлэг туслалцаа зөвхөн шаардлагатай үед түр хугацаанд л ашиглагддаг төдийгүй онцгой байдлын тодорхой ажиллагаануудад бэлтгэгдээгүй байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. НҮБХХ-өөс Монголд гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр үзүүлэх тусламжийн хүрээ

Энэхүү төсөл нь Монгол улсын засгийн газар болон бусад хөгжлийн түншүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулсан 2012-2016 онд хэрэгжих Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн тусламжийн хүрээний \НҮБХТХ\ зорилтуудыг хэрэгжүүлэхэд дөхөм болно. НҮБХТХ нь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааг бүх түвшний бүх хөтөлбөрт уялдуулан тусгах замаар эмзэг байдлыг бууруулж, гамшигтай тэмцэх чадавхийг нэмэгдүүлэхийг зорьдог. Үүнээс гадна орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийг бууруулах чадавхийг нэмэгдүүлэх асуудлыг шийдэх шаардлагатай байгааг НҮБХТХ хүлээн зөвшөөрч байна.

НҮБХТХ нь 2009-2010 оны зудын дараа боловсруулагдсан ба зудын үр дагаврыг арилгаж хэвийн байдалд орох оролдлого нь гамшигтай тэмцэх бэлтгэлтэй байж,

¹ Гамшгийн эрсдлийн бууруулах түншлэлийн зөвлөл, малчдын бүлэг, өөртөө туслах бүлгүүдийг цаашид орон нутгийн бие даасан-засаглалын байгууллага гэж нэрлэнэ

бүх түвшинд (нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийг оролцуулан) гамшгийн менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах шаардлагатай байгааг харуулсан. Үүнээс гадна НҮБХТХ-д гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд уур амьсгалын өөрчлөлтийг анхааран үзэх, уур амьсгалын эрсдэл үүсгэгч хүчин зүйлс, үр дагаврын талаарх ойлголтыг сайжруулах, мөн нийгмийн эмзэг бүлэг, иргэдийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үр дүнтэй, зардал багатай аргыг олох нь чухал болохыг цохон тэмдэглэсэн. НҮБ-ын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар нь гамшгийн эрсдлийн бууруулах ажиллагааг дэмжих үүднээс дараах зорилго тавин ажиллаж байна:

- Салбар хоорондын төлөвлөлт, зохицуулалт, харилцаа холбоо, мэдээлэл солилцох болон сүлжээний үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, түүнд дасан зохицох хувилбаруудад дүн шинжилгээ хийх, ингэхдээ нийгмийн эмзэгт бүлгийг анхааран үзэх
- Хөдөө аж ахуйн салбарын гамшигтай тэмцэх бэлтгэлийг сайжруулах
- Олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах, гамшгийн эрсдлийг бууруулах элементүүдийг боловсролын хөтөлбөрт тусгах, онцгой байдлын үед цаг алдахгүй авах арга хэмжээг зохицуулах механизмыг бий болгоход нь туслах,
- Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийг бууруулахдаа сайн дурын үйл ажиллагааг ашиглах

2.2. Төслийн стратеги

Энэхүү төслийг НҮБХХ-өөс гаргасан 2000-2010 оны Хөгжлийн үр дүнгийн үзүүлэлт, 2008-2011 онд хэрэгжсэн Гамшгийн менежментийн хөтөлбөрийн эцсийн тайлан, үнэлгээ, мөн хөгжлийн бусад түншүүдийн оролцооны байдал болон 2011 онд холбогдох олон талуудтай хийсэн ярилцлага, зөвлөгөө зэрэгт тулгуурлан боловсруулсан. Гол стратегиуд:

Үндэсний тэргүүлэх чиглэлүүдийг дэмжих: улс орны хувьд түгээмэл байгаа эмзэг байдал болон гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг шийдвэрлэх зорилгоор тус төсөл нь “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”, “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-т тусгасан хот, хөдөөгийн гамшгийн эрсдлийн менежментийн үйл ажиллагаа, 2.2.1, 2.2.3 болон 2.2.5 \хайрцаг 1\ -д заасан стратегийн зорилтуудыг дэмжих болно. Төслийн хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүд нь Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, МХЗ-д тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц стратеги болон Уур амьсгалын эрсдлийн менежментийн үндэсний стратегитэй бүрэн нийцэх болно.

Өмнөх сургамж, амжилтдаа тулгуурлах: НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжиж буй гамшгийн эрсдлийн менежментийн хөтөлбөр нь үндэсний хэмжээнд гамшгийн менежментийн чадавхийг бэхжүүлэхэд мэдэгдэхүйц амжилтад хүрсэн. Нөгөө талаар, энэхүү санаачилгыг хэрэгжүүлэхдээ үйл явц, үр дүнгээс нь илүү бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах асуудалд (төлөвлөгөө, тоног төхөөрөмж, сургалтын хөтөлбөрүүд гэх мэт) түлхүү анхаарсан учир урт хугацааны үр нөлөө нь харьцангуй бага байсан. Иймээс НҮБХХ-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар 2012-2016 онд Монгол улсад хэрэгжүүлэх төслийн баримт бичигтээ гамшгийн

менежментийн бүтэц, зохицуулалт болон менежментийн чадавхийг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх, ялангуяа зуд, газар хөдлөлт зэрэг өргөн хүрээг хамардаг гамшигт онцгой анхаарах шаардлагатай болохыг дурьдсан.

Төслийн хүрээнд мөн орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийн менежмент хариуцсан байгууллагын бүтэц зохион байгуулалт сул, тодорхойгүй байгаа асуудлыг шийдвэрлэх болно. Иргэд, олон нийтэд тулгуурлан амжилттай хэрэгжүүлсэн гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах болон хор уршгийг арилгах туршлагаа дахин хэрэгжүүлэх болно. Түүнчлэн, НҮБХХ-ийн гамшгийн менежментийн төслийн гуравдугаар үе шатны эцсийн үнэлгээний тайланд санал болгосон тодорхой зөвлөмжүүдийг энэ шатны төслийн үйл ажиллагаандаа харгалзан үзнэ. Тухайлбал:

- Байгаль орчин, эрсдэл болон нөөцийн хувьд харилцан адилгүй хот, хөдөөгийн нөхцөл тус бүрт тохирсон ялгаатай гамшгийн эрсдлийн менежментийн ажлыг санаачлан хэрэгжүүлэх
- Төсөл, хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагаанд хувийн хэвшлийг оролцуулах зорилготой ажил санаачлан туршилтаар хэрэгжүүлж, энэ туршлага дээрээ үндэслэн илүү том стратегийг хэрэгжүүлэх
- Төслийн 3 дугаар үе шатны баримт бичигт тусгагдсан уламжлалт арга ухааныг хөдөө, орон нутаг, аймаг болон улсын хэмжээнд сургалт, үйл ажиллагааны өвөрмөц хэлбэрээр олон нийтэд түгээх
- Одоо туршиж байгаа орон нутгийн цаг агаарын урьдчилсан мэдээ болон эрт зарлан мэдээллэх тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлэх
- Гол оролцогчид, төлөөллүүдийг (МБ, хотын оршин суугчид, өөртөө туслах бүлгүүд, төрийн болон төрийн бус байгууллагуудын техникийн ажилтнууд, сумын засаг захиргаа) оролцуулсан харилцаа холбооны стратегийг бий болгон хөгжүүлэх:
- Цаашид төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд шууд оролцох бүх байгууллага, хувь хүмүүсийн хяналт тавьж, үнэлгээ хийх чадавхи болон хүйсийн тэгш оролцоог хангах дүн шинжилгээг бэхжүүлнэ.

Хот, хөдөөгийн хүн амын аюулын эрсдэл, эмзэг байдал ба хэрэгцээ шаардлагын ялгаатай байдлыг харгалзах: Хөдөөгийн хүн амд ихээр нөлөөлдөг удаан явцтай гамшгууд (жишээ нь ган, зуд болон уур амьсгалын холбогдолтой бусад аюул ослууд) болон хот, хөдөөгийн хүн амд аль алинд нь нөлөөлдөг хурдан явцтай гамшгуудын (гэнэтийн үер, ой, хээрийн түймэр, газар хөдлөлт, химийн хорт бодис алдагдах, бохирдол, зам тээврийн осол гэх мэт) нөлөөлөл, хор уршгийг бууруулахын тулд хот ба хөдөөгийн нөхцөлд өөр өөр арга барилаар хандах хэрэгтэй. Хотод хүн ам шигүү суурьшиж байгаатай холбоотой газар хөдлөлт, гэнэтийн үерийн аюул нүүрлэх болсон ба энэ асуудлыг төслийн хүрээнд эн тэргүүнд хэрэгжүүлэх болно. Товчхон хэлвэл төслийн үйл ажиллагаа нь газар зүйн бүс нутгуудад тохиолдож болзошгүй гамшгийн төрөл тус бүрт тохируулан, тухайн газар нутгийн оршин суугчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах болно.

Сайн дурынхны оролцоо, шинэлэг санаачилгыг дэмжих механизмыг бүрдүүлэх: Нутгийн иргэдийн сайн дурын оролцоог дэмжих ажлын хүрээнд орон нутгийн гамшгаас хамгаалах штаб болон өөртөө туслах бүлгүүдийг чадавхижуулах хэрэгцээ шаардлага, тэдний бодитой, тогтвортой гүйцэтгэх үүрэг хариуцлагыг тодорхойлж, сайн дурын ажлыг зохицуулан хөгжүүлэх албан ёсны механизмыг тодорхой болгоно. Мөн үйл ажиллагааны чиг үүрэг, хууль эрх зүйн статусыг тодорхой болгож, онцгой байдалд бэлэн байх, хор уршгийг арилгах үйл ажиллагааны сайн дурынхны оролцоог урамшуулах тогтолцоог олон улсын

туршлага дээр үндэслэн тодорхойлно (гамшгаас хамгаалах ажилд сайн дураар оролцсоныг цэргийн алба хаасанд дүйцүүлэн тооцно). Байгууллагын, хөгжлийн болон институцийн гамшгийн эмзэг байдал, хор хохирлыг бууруулах үйл ажиллагаа явуулахад ашиглах гамшгийн эрсдлийн үзүүлэлтийн системийг бий болгон хөгжүүлэхдээ бас эдгээр асуудлыг харгалзана. Төслийн ажилд сайн дурын бусад байгууллагууд, тухайлбал НҮБ-ын сайн дурынхны туршлагыг харгалзан үзэхээс гадна тухайн улс дахь НҮБ-ын сайн дурынхныг оролцуулах болно. Төслийн орон нутгийн түвшинд явуулж буй үйл ажиллагаанд тухайн улсын, боломж гарвал НҮБ-ын сайн дурынхны дэмжлэг туслалцааг авч байна.

Гамшгийн эрсдлийг бууруулахад жендерийн асуудлыг тусгах: Гамшгийн бэлэн байдлыг хангах, түүний хор уршгийг арилгах ажилд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байна. Гамшгийн менежментийн төслийн өмнөх үе шаттай адил эмэгтэй, эрэгтэй, хөгшин, залуу, эмзэг бүлгийн гээд бүх хүмүүсийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг төслийн бүх үйл ажиллагаанд харгалзах буюу жендерийн асуудлыг тусган ажиллана. Бүх бодлогын баримт бичиг, заавар журам боловсруулахдаа жендерийн асуудлыг тусгах, гамшгийн эрсдлийн менежментийн үйл ажиллагаа, төлөвлөх, төсөв зохиох, үзүүлсэн тусламж үйлчилгээгээ хянах мэдээллийг цуглуулах, түгээхдээ эрэгтэй, эмэгтэйчүүдийг жигд татан оролцуулах нөхцөлийг ханган ажиллана. Практикт хэрхэн хэрэгжүүлэх талаар НҮБХХ-ийн хүйсийн тэгш байдлын зөвлөхүүдтэй зөвлөлдөн, хүйсийн үзүүлэлтүүдийг нарийвчлан гаргаж, ажлын төлөвлөгөөндөө оруулна.

Тогтвортой байдлыг хангахад анхаарах зүйлүүд: Нутгийн иргэдэд өөрсдөө гамшигт өртөх эрсдлээ бууруулж, чадавхиа нэмэгдүүлэх шаардлагатайг ойлгуулж доороос дээш чиглэсэн арга барилыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Гамшигтай тэмцэх чадавхитай болсон иргэдийн чадавхийг тогтвортой байлгах үүднээс орон нутгийн захиргааны байгууллагын чадавхийг мөн зэрэг бэхжүүлнэ. Гамшгийн эрсдлийг бууруулах ажилтай холбоотой орон нутгийн захиргааны гүйцэтгэх үүргийн дутагдалтай талуудыг шийдвэрлэх ба үүнд албан ёсоор гүйцэтгэх үүрэг хариуцлага бага, байнгын үйл ажиллагаа явуулах бүтэц, санхүүжилт болон урамшууллын механизм дутмаг зэрэг асуудал орж байна. Одоогийн ГЭБТЗ-ийн чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ ОБЕГ-ын иргэдэд хүрч ажиллах явдлыг сайжруулна. Төсөл дуусгах стратегийг ОБЕГ болон холбогдох бусад талуудтай хамтран төслийн хэрэгжих хугацаа дуусахаас өмнө боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2. Төслийн зорилго, зорилтууд

Гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах болон зохицуулалтын механизмын тусламжтай гамшгийн менежментийн төвлөрлийг багасгаж хот, хөдөөгийн ядуу хүн амын эмзэг байдлыг бууруулахад төслийн гол зорилго оршино. Төслийн зорилт нь орон нутгийн гамшгийн менежментийн механизмыг албан ёсны тодорхой хэлбэрт оруулж, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгон, хот ба хөдөөгийн нөхцөлд тохирсон гамшгаас хамгаалах, гамшгийн аюулд бэлэн байх болон хор уршгийг арилгах арга барилыг ашиглах замаар гамшгийн менежментийн чадавхийг бэхжүүлэх явдал юм.

Төслийн дүнд гарах харилцан уялдаа бүхий дараах гурван үр дүн нь төслийн зорилго биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ:

1-р үр дүн: Бодлого, зохицуулалтын бүтэцтэй болсноор холбогдох талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож гамшгийн эрсдлийг бууруулах болон гамшгийн менежментийн ажлыг сайжруулна

2-р үр дүн: Хот ба хөдөөгийн эмзэг байдлын онцлогт тохирсон үйл ажиллагааны дүрэм журам, чадавхи бүхий орон нутгийн гамшгийн менежментийн механизмтай болно

3-р үр дүн: Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, хор уршгийг арилгах үр дүнтэй механизм улам сайжран бэхжинэ

2.3. Төслийн үйл ажиллагаа, үр дүн

1-р үр дүн: Бодлого, зохицуулалтын бүтэцтэй болсноор холбогдох талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож гамшгийн эрсдлийг бууруулах болон гамшгийн менежментийн ажлыг сайжруулна

Гамшгийн эрсдлийн менежментийн бүх байгууллага, зохион байгууллын бүтцэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж бүх түвшний гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхой болгоно. Дүн шинжилгээ хийхдээ одоогийн бүтэц, зохицуулалт, төлөвлөх ба төсөвлөх механизмыг голлон авч үзэх ба гарсан үр дүнд нь үндэслэн хамгийн үр дүнтэй арга механизмыг тодорхойлж, хот ба хөдөөгийн хүн амын гамшгийн эрсдлийг бууруулах зорилгоор бусад улсын туршлагатай харьцуулсны үндсэн дээр гамшгийн эрсдлийг харуулах систем бий болгон хөгжүүлнэ. Бодлогын санал зөвлөмжүүдийг холбогдох талуудтай зөвлөж, харилцан ярилцсаны дараа баталгаажуулна. Орон нутгийн түвшинд үүрэг хариуцлагыг тодорхойлохдоо нутгийн иргэд, олон нийт бие даан юу хийж чадах, үүнд нь ямар дэмжлэг туслалцаа хэрэгтэй болохыг анхаарч үзнэ. Аймаг, дүүргийн Онцгой байдлын газар, хэлтсүүд ГЭБТЗ, хот ба хөдөөгийн иргэдийн гүйцэтгэх үүргийг тус тусад нь тодорхой болгож чадавхийг нь бэхжүүлнэ. Ингэснээр энэхүү төсөл нь гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг хөгжлийн төлөвлөлтөд тусгаж, төвлөрлийг сааруулах үйл явц болон олон удаа хэлэлцэж, орон нутгийн хэмжээнд туршиж үзсэний үндсэн дээр хийж буй үндэсний бодлого, дүрэм журмын нэмэлт өөрчлөлтийг дэмжих боломжтой болж байна.

1-р үр дүнг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд:

1. Гамшгийн эрсдлийн менежменттэй холбоотой үүрэг, хариуцлагыг тодорхой болгохын тулд одоогийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн болон бодлогын хүрээг хянаж үзэх
2. Олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийг бууруулах менежмент, зохицуулалт, санхүүжилтийн тохиромжтой механизмыг хөгжүүлэх
3. Орон нутгийн түвшинд /дүүрэг, хороо, аймаг, сумыг оруулан/ гамшгийн менежментийн механизмыг албан ёсоор бий болгоход дэмжлэг үзүүлэх

2-р үр дүн: Орон нутгийн гамшгийн менежментийн механизм хот ба хөдөөгийн эмзэг байдлын шинж чанарт зохицсон чадавхи, үйл ажиллагаатай болно

Энэхүү төсөл нь орон нутгийн захиргаа, хот, хөдөөгийн иргэдэд гамшгийн эрсдлийг бууруулахад тулгарч буй бэрхшээлүүдийг хэрхэн системтэйгээр шийдвэрлэх талаар мэдлэг, чадвараа хуваалцан, харилцан суралцах боломж олгож, эмзэг иргэдийн гамшгийн эрсдлийг бууруулахад дэмжлэг үзүүлнэ. Мөн НҮБХХ-ийн гамшгийн менежментийн өмнөх шатны төслийн боловсруулан гаргасан “Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх аргачлал”-ыг ашиглахад нь туслах замаар нутгийн иргэдийг амьдарч буй орон нутгийнхаа эрсдлүүдийг тогтоон, үнэлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор олон

нийтийн гамшгийн эрсдэл болон эрт зарлан мэдээний талаарх ойлголт мэдлэг, хүлээн авах сэтгэл зүйг сайжруулахад онцгой анхаарсан үйл ажиллагаа явуулах нь төслийн нэг гол чиг үүрэг байна.

ОБЕГ нь ГЭБТЗ, хот хөдөөгийн иргэдэд техник, санхүүгийн болон материаллаг тусламж олгогч гол эх үүсвэр болсноор аймаг, дүүргийн Онцгой байдлын газар хэлтсүүдийн үйл ажиллагаа бэхжих болно. Төрийн байгууллагын худалдан авалтын жишиг болгох үүднээс Онцгой байдлын газар, хэлтсүүдэд аврах, эрэн хайх ажиллагааны хамгийн сүүлийн үеийн, дэвшилтэт тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлнэ. Тухайн орон нутгийн техник хэрэгсэл, мэдлэг чадварт тулгуурлан нутгийн иргэд, гамшгаас хамгаалах томилгоот бүлгүүдийг янз бүрийн аюул ослын чиглэлээр байнгын бэлтгэл, сургалтад хамруулна. Ийм байдлаар бүсийн хэмжээнд янз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулж, цагийн байдлаар хийх болон онцгой байдлын хор уршгийг арилгах дасгал сургууль явуулснаар орон нутгийн түвшинд мэдлэг, туршлага солилцох байдал сайжирна. Бүсийн хэмжээнд нөөцийн систем байгуулах нь онцгой байдлын зориулалтаар ашиглах улсын хөрөнгийг илүү үр дүнтэй зарцуулахад тусална.

Гамшигтай холбоотой мэдээллийг солилцоход зориулан хот, дүүрэг, аймаг, сумын түвшинд эмзэг байдал, аюулын зураглал, аргачлал болон програм зохиож эдгээрийг хөгжлийн төлөвлөлт, гамшгаас урьдчилан сэргийлэх болон гамшгийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглана. Сайн дурынхны дэмжлэгтэй орон нутгийн гамшгаас хамгаалах томилгоот бүлгүүд болон штабуудыг эрт зарлан мэдээллэх, аврах, эрэн хайх ажиллагаа, анхны тусламж үзүүлэх, хоргодох байранд оруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зэрэг хор уршгийг арилгах янз бүрийн үйл ажиллагаанд бэлтгэнэ. Өмнө туршсан эрт зарлан мэдээллэх системүүдийг Ус, цаг уур орчны шинжилгээний газартай холбосноор цаг агаарын урьдчилсан мэдээ түгээх байдал сайжирч, бусад газруудад зардал хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх боломжтой болно.

Төлөвлөсөн үйл ажиллагаа:

- 2.1 Янз бүрийн арга хэрэгсэл ашиглан аюул осол, эмзэг байдал болон хувь хүний авах хариу арга хэмжээний талаарх иргэд, олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх
- 2.2 Орон нутгийн онцгой байдлын байгууллагуудад гамшгийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, чадавхийг нь бэхжүүлэх
- 2.3 Гамшгаас хамгаалах томилгоот бүлгүүдийг бий болгон, хор уршгийг арилгах янз бүрийн ажиллагаанд бэлтгэх
- 2.4 Аюул, эмзэг байдлын талаар эрт сэрэмжлүүлэх, олон нийтэд түгээх механизмыг бэхжүүлэх

3-р үр дүн: Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, хор уршгийг арилгах үр дүнтэй механизмыг түгээн дэлгэрүүлэх

Энэ үр дүнд хүрэхээр төлөвлөсөн ажлууд ба чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэг, мэдээллийг сайжруулах үйл ажиллагаанууд нь бодлогын түвшний оролцооны үндэс болно. Өөрөөр хэлбэл, орон нутгийн түвшинд хуримтлуулсан туршлага, авсан сургамжаа үндэсний бодлого, дүрэм журамд тусгахаар ажиллана. ГЭБТЗ болон иргэдийн үйл ажиллагааны механизм нь ашиглаж буй загварыг улам сайжруулан, холбогдох бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулахад дэмжлэг болно. Боловсруулж баталсан дүрэм журмуудад тулгуурлан хот, дүүрэг, аймаг, сумын түвшинд янз бүрийн гамшгийн аюулд бэлэн байх болон хор уршгийг бууруулах төлөвлөгөөнүүдийг боловсруулна. Төлөвлөгөө боловсруулах ажилд эмзэг байдлын зураглал,

эрсдлийн үнэлгээ, дүн шинжилгээ, аюулын бүсчлэл, нөөцийн бүртгэл мэдээллийг гаргах болон хор уршгийг арилгах ажиллагааны бүтэц, зохион байгуулалт зэрэг багтах ба ингэхдээ жендерийн асуудлыг тусгаж ажиллана. Үүнээс гадна, төслийн гуравдугаар шатанд амжилттай хэрэгжүүлсэн практикуудаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ба үүнд сумдад байгуулагдсан гал унтраах баг, явуулын гэр мэдээллийн төвүүд болон эрт зарлан мэдээллэх систем зэрэг орж байна.

Төлөвлөсөн ажлууд:

1. Хот, хөдөөд бүс нутгийн болон тухайн газар нутгийн онцлогт нийцсэн гамшгийн менежментийн механизмыг байгуулахад дэмжлэг үзүүлэх
2. Олон салбарыг хамарсан, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан, жендерийн асуудлыг хангасан орон нутгийн (аймгийн) гамшигтай тэмцэх төлөвлөгөөг үндэсний төлөвлөгөөнд үндэслэн боловсруулах; төлөвлөгөөндөө гамшгийн бэлэн байдал, янз бүрийн гамшгийн хор уршгийг бууруулах болон арилгах стратегийг тусгасан байна.
3. Амжилттай хэрэгжүүлсэн гамшгийн эрсдлийг бууруулах туршлагыг орон нутгийн түвшинд сайн дурынхны дэмжлэгтэй түгээн дэлгэрүүлэх

2.4. Төслийн үр дүнгийн мэдээлэл

Жилийн үйл ажиллагааны зорилт, үзүүлэлтүүдийг нэгдүгээр хавсралтад нарийвчилан харуулсан.

2.5 Төслийн төсөв ба ажлын төлөвлөгөө

Төсвийн мэдээллийг төслийн жил, үйл ажиллагаагаар нь задлан хоёрдугаар хавсралтад оруулав.

2.6. Түншлэл, зохицуулалт

Төв ба орон нутгийн удирдлага, гадны хөгжлийн түншүүд, төрийн бус байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай бий болгосон хамтын ажиллагаа, үйл ажиллагааны зохицуулалт нь төслийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, үр ашгийг нь нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй болохыг өмнөх шатны төслүүд ч батлан харуулсан.

Хүснэгт 2. Төслийн хамтын ажиллагааны стратеги

Холбогдох байгууллагууд	Чиг үүрэг
Төрийн байгууллагууд	
Шадар сайдын алба\ Онцгой байдлын ерөнхий газар	Төслийн үр дүнг хариуцах төсөл хэрэгжүүлэгч түнш. Бодлогын удирдамжаар хангаж, төсөл хэрэгжүүлэхэд ажиллах хүчний дэмжлэг үзүүлнэ.
Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц , Цөлжилттэй тэмцэх конвенцийг хэрэгжүүлэх болон байгаль хамгаалахтай холбоотой бүх асуудлыг хариуцна. Энэ нь төсөл хэрэгжүүлэх түнш бөгөөд дараах агентлагуудаараа дамжуулан төслийн хэрэгжилтийг

Холбогдох байгууллагууд	Чиг үүрэг
	хангана. Үүнд: Усны газар, Ойн газар, Тусгай хамгаалалттай нутгуудын удирдлагын газар
Үйлдвэр , хөдөө аж ахуйн яам	Хөдөө аж ахуйн салбарын гамшгийн эрсдлийг бууруулах болон малын халдварт өвчинтэй тэмцэх ажил дээр голлон хамтран ажиллана.
Зам, тээврийн яам; Барилга, хот байгуулалтын яам	Газар хөдлөлттэй холбоотой бэлэн байдлыг хангаж, хор уршгийг арилгах үйл ажиллагаа болон барилгын аюулгүй байдал, стандарт, норм нормативтай холбогдсон асуудлаар хамтран ажиллана.
Орон нутгийн захиргаа /зорилтот аймаг, сумд, Улаанбаатар хот/	Орон нутагт төслийн хэрэгжилтийг хангах болон орон нутгийн бодлого, хөгжлийн төлөвлөлтөд гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг тусгахад дэмжлэг үзүүлнэ.
Эрдэм шинжилгээний байгууллага	
Монгол улсын Шинжлэх ухааны академи; Эрдэм шинжилгээний байгууллагууд	Эрт зарлан мэдээлэх, цаг агаарын урьдчилсан мэдээ болон түүнийг иргэдэд түгээх асуудал дээр Ус, цаг уурын институт ба Цаг уур, орчны шинжилгээний газар хамтран ажиллана.
Иргэд, хувийн хэвшил	
Орон нутгийн иргэд	Төсөл хамтран хэрэгжүүлэгч, төслийн үр дүнг шууд хүртэх зорилтот бүлгүүд байх бөгөөд орон нутгийн гамшгийн менежментийн оновчтой механизмыг түгээн дэлгэрүүлнэ.
Үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагууд	Гамшгийн эрсдлийг бууруулах бэлэн байдал болон хувь хүмүүсийн авах арга хэмжээний талаар олон нийтэд мэдээллэх
Хөгжлийн түншүүд, төрийн бус байгууллагууд	
НҮБ-ын агентлагууд (Монгол дахь Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн Сан , НҮБ-ын Хүн амын Сан), Хүмүүнлэгийн үндэсний баг (НСТ), Гамшгийг бууруулах олон улсын стратеги	2012-2016 онд гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг хариуцсан НҮБ-ын агентлагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулна. Төслийн үйл ажиллагаа нь Монгол улс дахь НҮБ-ын хүмүүнлэгийн багийн хэрэгжүүлж буй кластерын арга барил, зохицуулалтын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлнэ. Гамшгийн эрсдлийг бууруулах олон улсын стратеги нь НҮБХХ –ийн гамшгийн эрсдлийг бууруулах удирдлагыг сайжруулах хүчин чармайлтад дэмжлэг үзүүлнэ.
Улаан загалмай, АДРА, Жайка буюу Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн зөн	Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгслээр хангахад туслалцаа үзүүлнэ. Одоо хэрэгжиж буй болон цаашид хэрэгжих төслүүдийн үйл ажиллагаатай нийцсэн, бие биенийхээ үйл ажиллагааг нөхсөн, дэмжсэн байхад анхаарна. /шулууны томуу, хөдөө аж ахуйн салбарын эрсдлийг бууруулах, индексэд суурилсан малын даатгал, газар хөдлөлтийн эрсдлийн зураглал гэх мэт/

2.6. Төсөл хэрэгжүүлэх зорилтот газрууд

Төсөл хэрэгжүүлэх газруудыг ОБЕГ, орон нутгийн засаг захиргаа болон холбогдох бусад байгууллагуудтай зөвлөлдөж сонгосон. Өмнөх шатны төслүүдийн хүрээнд хэрэгжсэн үр дүнтэй арга туршлагыг энэ төслөөр шинэ аймаг сумдад хэрэгжүүлнэ. Энэ шатны төсөл хэрэгжих сумдын гуравны нэг нь

шинэ, үлдсэнийг өмнөх шатны төсөл хэрэгжиж байсан сумдыг сонгосон бөгөөд, ингэснээр үр дүнтэй болох нь нэгэнт нотлогдсон практик, туршлагаудыг шинээр сонгосон газруудад хэрэгжүүлэх боломжтой болно. Үүнээс гадна энэ төслийн хүрээнд төслийн гуравдугаар шатанд байгуулагдсан өөртөө туслах бүлгүүдийг чадавхижуулан бэхжүүлж, үйл ажиллагааг нь тогтворжуулна.

Шинээр сонгогдсон сумдыг дараах шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан сонгосон:


- Үйл ажиллагааны зардлыг хэмнэх үүднээс 3-р шатны төсөл хэрэгжсэн сумдад харьцангуй ойр, төвлөрсөн байршилтай байх
- Байгалийн болон бусад аюул осол, гамшигт өртөмхий байх
- Сүүлийн 3 жилийн хугацаанд онцгой буюу гамшгийн байдал олон удаа гарсан байх
- Гамшгийн хор уршгийг арилгах чадавхи хангалтгүй байгаагаас шалтгаалан их хэмжээний хохирол учирсан байх
- Орон нутгийн удирдлагуудын хүсэлт

Хот суурин газар: Сүүлийн хориод жилд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудын хүн ам хурдацтай нэмэгдсэн. Жишээ нь 1990-2011 оны хооронд Улаанбаатар хотын хүн ам 70%-иар өссөн байна. Ойролцоох болон хол орших аймаг, сумдын иргэд амьжиргаа, эдийн засгийн байдлаа сайжруулах боломж хайн хот суурин газарт ирж суурьших нь ихэссэн. Гэхдээ Улаанбаатар хотод эдгээр хүмүүст хүрэлцэхүйц газар нутаг, дэд бүтэц байхгүй нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх чадавхгүй байгаа нь олон асуудал үүсгэж байна.

Гэр хороолол ямар ч төлөвлөлт, зохион байгуулалтгүйгээр нэмэгдэж байгаа нь газрын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, иргэдийг аюулд өртөх эрсдэлтэй газарт суурьшихад хүргэж байна. Орон нутгийн удирдлага, оршин суугчид учирч буй аюул ослынхоо хор уршгийг арилгах, хариу арга хэмжээ авах чадавхиар хязгаарлагдмал байна. Иймээс, эрсдлийн суурь үнэлгээ хийсний үндсэн дээр ГЭБТЗ ба өөртөө туслах бүлгүүдийг Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүд мөн Дархан зэрэг томоохон хотуудад байгуулах асуудалд анхаарна.

Хөдөө орон нутаг: Монгол улсад түгээмэл тохиолддог үер, ой, хээрийн түймэрт нилээд өртдөг Сэлэнгэ, Дорнод аймгуудыг шинээр сонгосон. Уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд Сэлэнгэ аймагт химийн гаралтай аюул осол их гардаг. 2012 онд Дорнод аймагт гарсан томоохон ой хээрийн түймрийн улмаас дөрвөн гал сөнөөгч, мөн Сэлэнгэ аймагт голын мөс цөмөрч хоёр хүн тус тус амиа алдсан. Энэ нь орон нутгийн түвшинд чадавхи муу, ялангуяа аврах, эрэн хайх ажиллагааны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хангалтгүй байсантай холбоотой. Дараах хүснэгтэд төсөл хэрэгжүүлэх сумдыг харуулав.

	Аймаг	Сум	Статус
1	Дорнод	Баян-Уул	Шинээр хэрэгжүүлэх
2		Баяндун	
3	Сэлэнгэ	Мандал	Шинээр хэрэгжүүлэх
4		Алтанбулаг	
5	Булган	Сэлэнгэ	Өмнө хэрэгжсэн
6		Тэшиг	
7		Сайхан	
8	Хэнтий	Жаргалтхаан	Өмнө хэрэгжсэн
9		Биндэр	
10	Дундговь	Говь-Угтаал	Өмнө хэрэгжсэн
11		Баянжаргалан	



Зураг 1. Төсөл хэрэгжүүлэх зорилтот газрууд

ГУРАВДУГААР ХЭСЭГ. МЕНЕЖМЕНТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү төсөл нь 2013 оны эхнээс 4 жилийн хугацаатай хэрэгжинэ. Төслийг хэрэгжүүлэхдээ **Үндэсний хэрэгжүүлэгчийн зааврыг** мөрдөнө. Гадаад хэрэг, худалдааны яам нь Монголд НҮБХХ-ийн техникийн хамтын ажиллагааг зохицуулах ажлыг хариуцна. ОБЕГ нь Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого ба Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлэх гол түнш байх бөгөөд төслийн үйл ажиллагаа, үр дүнг цаг хугацаанд нь гүйцэтгэх ажлыг хариуцаж, холбогдох чиг үүрэг бүхий бусад байгууллагууд, жишээ нь яамд, холбогдох агентлагууд, орон нутгийн удирдлага, онцгой байдлын газар, хэлтсүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

Төсөл нь Удирдах зөвлөл (өмнө нь **Төслийн удирдах хороо** гэж нэрлэдэг байсан) –ийн удирдлага, хяналтын дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд тус зөвлөл нь төслийн талаарх менежментийн шийдвэрийг нийтээрээ зөвшилцөн санал нэгтгэйгээр гаргах үүрэг хүлээнэ. Удирдах зөвлөл нь дараах гурван үндсэн чиг үүрэгтэй байна:

1. Төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг ерөнхийд нь хариуцна
2. Төслийн техникийн үндэслэлтэй холбоотой удирдамжаар хангана
3. Төслийн үр шимийг хүртэгчдийн хувьд төслийн үйл ажиллагаа үр дүнтэй болох явдлыг хангана

Удирдах зөвлөлийг шадар сайдын томилсон шадар сайдын ажлын албаны өндөр албан тушаалын ажилтан удирдах ба бүрэлдэхүүнд нь Үр дүнд чиглэсэн менежментийн гарын авлагын дагуу дараах байгууллагуудаас томилогдсон өндөр албан тушаалын ажилтнууд байна. Үүнд:

1. Шадар сайд эсвэл Шадар сайдын томилсон ОБЕГ-ын дарга – удирдах зөвлөлийн дарга байна
2. ОБЕГ (хэрэв удирдах зөвлөлийн дарга нь шадар сайд бол)
3. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (ойн эсвэл аюултай бодис материалын асуудал хариуцсан хэлтсийн төлөөлөл байна)

4. НҮБХХ (төсөл хариуцсан ажилтан) – төслийн хяналт, үнэлгээний асуудлыг хариуцна
5. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам (мал аж ахуй/бэлчээрийн менежмент хариуцсан хэлтэс)
6. Барилга, хот байгуулалтын яам (барилгын аюулгүй ажиллагаа, стандарт, норм, дүрэм журам)
7. Улсын мэргэжлийн хяналтын газар
8. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
9. Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
10. Зүүн бүсийн сумдын засаг захиргааны төлөөлөл
11. Төвийн бүсийн сумдын засаг захиргааны төлөөлөл

Удирдах зөвлөлийн гишүүнд аливаа цалин хөлс, урамшуулал олгохгүй. Удирдах зөвлөлийн гишүүдийг төслийн үндэсний захирлын нэр дэвшүүлэн санал болгосноор холбогдох байгууллагуудын удирдлага томилж, энэ тухай албан бичгээ төслийн үндэсний захиралд албан ёсоор өгнө. Төслийн үндэсний зохицуулагч нь саналын эрхгүй гишүүн байх бөгөөд удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэнэ. Удирдах зөвлөлийн ажлын удирдамжийг 4-р хавсралтаар оруулав.

Шаардлагатай бол төслийн үндэсний захирлын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллах мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн төсөл хэрэгжүүлэгч баг бүрдүүлнэ. Гэхдээ төсөл хэрэгжүүлэх нэгж нь төслийн гуравдугаар шаттай харьцуулахад хамаагүй цөөн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд төслийн үндэсний зохицуулагчийн удирдлага дор ОБЕГ-т байрлан ажиллана. Төслийн үндэсний зохицуулагч нь тухайн салбарт мэргэжсэн тухайн улсын иргэн байх ба төслийн хугацаа дуустал төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллана. Төслийн үндэсний зохицуулагчийн үндсэн үүрэг нь тухайн төслийн үйл ажиллагааг төслийн баримт бичигт заасан хугацаа, төсөвт багтаан шаардсан чанарын түвшинд зорилтот үр дүнд хүргэх явдал юм. Төслийн үндэсний зохицуулагчийн ажлын удирдамжийг 5-р хавсралтаар оруулав.

Төслийн үндэсний зохицуулагч нь шадар сайдын томилсон ОБЕГ-ын өндөр албан тушаалтан болох төслийн үндэсний захирлын удирдлага, зааврын дагуу ажиллана. Төслийн үндэсний захирал нь Засгийн газрын нэрийн өмнөөс төслийг зохих ёсоор хэрэгжүүлэх асуудлыг хариуцаж, төслийн хэрэгжилтэд хяналт тавина. Төслийн үндэсний захирлын ажлын удирдамжийг 6-р хавсралтаар оруулав. Төслийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах үүднээс шадар сайд төслийн үндэсний захирлын эзгүйд түүнийг орлох хүнийг томилно.

НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар нь төслийн төсөв зарцуулалтад хяналт тавих, төслийн үндсэн болон зөвлөх ажилтнуудыг сонгон ажиллуулах, үндсэн болон туслах гэрээ байгуулах, тоног төхөөрөмж худалдан авахад болон ОБЕГ-ын хүсэлтээр өөр бусад асуудалд туслалцаа үзүүлэх замаар төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар нь төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, хандивлагчдын хандив, мөнгөн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг хангана. Санхүүгийн гүйлгээ хийх, тайлан гаргах болон аудит хийхдээ үндэсний болон НҮБХХ-ийн үндэсний хэмжээнд төсөл хэрэгжүүлэх тухай дүрэм журам, зохицуулалтыг мөрдөнө. НҮБХХ нь төслийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавих үүргээ Улаанбаатар хотод байрлах суурин төлөөлөгчийн газрын тухайн төсөл хариуцсан ажилтнаар дамжуулан хэрэгжүүлнэ. Тухайн төсөл хариуцсан мэргэжилтэн нь төслийн үйл ажиллагааг төслийн үндэсний захирал, төслийн баг

болон холбогдох үндэсний байгууллагуудтай уялдуулан зохицуулах ажлыг хариуцна.

Бангокт байрлах НҮБХХ-ийн Хямралаас урьдчилан сэргийлэх, сэргээн босгох газар (Женевт байрлах ХУССБГ-ын Гамшгийн асуудлаарх бүсийн зөвлөх, гамшгийн аюулыг бууруулах хэлтсийг оруулан) болон Женевт байрлах НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах албаны холбогдох хэлтэс нь НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газраас үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй аюул ослыг багасгахад онцгой анхаарсан гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааг дэмжин, зохицуулах хүрээнд Монгол улс дахь НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газарт техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.

Төслийн үндэсний зохицуулагч нь төсөл хэрэгжүүлэхдээ ОБЕГ болон аймаг, сумдын Онцгой байдлын газруудаас техникийн, ажиллах хүчний болон бусад дэмжлэг туслалцаа авна.


НҮБХХ нь өөрийнхөө үйл ажиллагаа болон хяналт тавих чиг үүргийг Улаанбаатар хот дахь Суурин төлөөлөгчийн газрын томилгоот ажилтнаар гүйцэтгүүлэх ба тэр ажилтан нь төслийн үйл ажиллагааг Төслийн үндэсний захирал, төслийн баг болон бусад хамтрагч талууд хоорондын харилцан уялдааг хангах үүрэг хариуцлага хүлээнэ.

Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төслийн баг дараах бүрэлдэхүүнтэй байх нь чухал:

- Төслийн үндэсний зохицуулагч
- Төсөл хэрэгжүүлэх зорилтот газруудын мэргэжлийн баг бүрэлдэхүүн – Онцгой байдлын газрын дарга
 - Дорнод
 - Сэлэнгэ
 - Булган
 - Хэнтий
 - Дундговь
 - Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
 - Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
 - ОБЕГ-ын удирдах ажилтнууд /шаардлагатай бол/
- Захиргаа, санхүүгийн ажилтан
- Сум, хороодын төслийн орон нутгийн зохицуулагчид, НҮБ-ын сайн дурын ажилтнууд

Орон нутгийн зохицуулагчид нь сум, хороонд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Хөдөө орон нутагт хамтын шийдвэр гаргах, ил тод байдлыг хангах болон сайн засаглалыг хөгжүүлэхийн тулд сум, хорооны Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөлүүд эсвэл төрийн ижил төстэй байгууллага нь орон нутгийн түвшинд төслийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргана, харин орон нутгийн зохицуулагчид нь ГЭБТХАЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү ГЭБТХАЗ нь сум/хорооны засаг дарга, сумын эмнэлэг, шуудан, цаг уур судлалын газар болон сургуулийн удирдлага, сум/хорооны иргэдийн нийтийн хурлын дарга, мөн дор хаяж 3 үйл ажиллагаагаа явуулж буй малчдын/өөртөө туслах бүлгийн ахлагчаас бүрдэнэ. Зөвлөлд гамшгийн эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэх сонирхол бүхий орон

нутгийн хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийн төлөөлөл болон тодорхой орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компаний төлөөллийг мөн оруулахыг хөхүүлэн дэмжинэ. Төслийн удирдлага, менежментийн ерөнхий бүтцийг доорхи хүснэгтэд харуулав.



Дөрөвдүгээр хэсэг. Хяналт ба үнэлгээ

4.1 Хяналтын үйл ажиллагаа

Хяналт мониторингийн механизмыг тодорхойлохдоо төслийн үйл ажиллагаанд олон талууд үр дүнтэй хяналт тавих боломжтой байхад анхаарах ба хяналт тавихдаа төслөөр дамжуулан, тухайн газар дээр нь очиж шууд хяналт тавих, байнгын мэдээ, тайлангаар хангах, болон санхүүгийн зардлыг бүртгэх зэрэг аргыг ашиглана. Эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэхэд төсөл хэрэгжүүлэгч баг дэмжлэг үзүүлэх ба харин төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үнэлгээ өгөх үүргийг НҮБХХ-ийн тусгай ажлын хэсэг хариуцна. Хяналтын үйл ажиллагаа нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ:

- **Үр дүнд чиглэсэн/үр дүнгийн баримжаатай:** Төслийн менежментийг сайжруулж, зорилтот үр дүнд нь хүргэх зорилгоор үйл ажиллагааг нь зохих ёсоор үнэлж дүгнэнэ.
- **Чанарын баталгаа:** Төслийн үр шимийг дээд зэргээр хүртэхийн тулд төслийн үйл ажиллагааг чанартай хэрэгжүүлэх нөхцөлийг хангах ба ингэхдээ хэрэгжилтэд хяналт тавих замаар засаж сайжруулах асуудлуудыг тодорхойлон шаардлагатай нэмэлт дэмжлэг туслалцааг цаг хугацаа алдалгүй үзүүлэхэд анхаарна.
- **Хариуцлага:** Хөрөнгийн санг тодорхойлсон зорилтуудаа хэрэгжүүлэхэд зохих ёсоор ашиглаж байгаа эсэхэд санхүүгийн шалгалт хийх замаар төсөл хөтөлбөрийн нөөц хөрөнгийг хариуцлагатай зарцуулах явдлыг хангах ба хяналт хийх байгууллага нь энэ ажлыг гүйцэтгэх хангалттай эрх хэмжээтэй байна.

- **Ил тод байдал:** Төслийн үйл ажиллагаа, санхүү болон үр дүнгийн талаарх мэдээлэл холбогдох бүх талуудад ил тод байх нөхцлийг хангана.
- **Суралцах :** Төслийн хэрэгжилтийн явцыг сайжруулах, шинэ санаачилга гаргахад суралцах болон НҮБХХ, Монгол улсын Засгийн газар ба хөгжлийн түншүүдийн гамшгийн эрсдлийг бууруулахаар ажиллах явцад олсон амжилт, туршлага, сургамжийг олж тодорхойлох механизмтай байхад анхаарна.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд төслийн 4-р үе шатны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авна:

- **Өдөр тутмын хяналт:** Төслийн үндэсний зохицуулагч нь НҮБХХ-ийн хяналтын дор төслийн хэрэгжилтийн байдал, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хүлээнэ. Төсөл хэрэгжүүлэгч баг нь төслийн жилийн ажлын төлөвлөгөө, түүний үзүүлэлтүүдэд үндэслэн төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа бэрхшээл, ажлын хоцрогдлын талаар НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газарт мэдээллэх ба ингэснээр алдаа дутагдлыг цаг алдалгүй залруулж, шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлэх боломжтой болно.
- **Тогтмол хугацаанд хийх хяналт шалгалт:** НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар нь төсөл хэрэгжүүлэгч багтай улирал тутам уулзаж төслийн хэрэгжилтэд хяналт тавих ба ингэснээр төсөлтэй холбоотой аливаа асуудлыг тухай бүрт нь шийдэж, төслийн үйл ажиллагаа тасалдалгүй хэвийн үргэлжлэх нөхцөл хангагдана. НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар ба Удирдах зөвлөл нь жил бүр төсөл хэрэгжиж буй газруудад очиж төслийн үйл явцтай газар дээр нь танилцах ба суурин төлөөлөгчийн газар энэ тухай тайлан мэдээг бэлтгэн холбогдох бүх талуудад хүргүүлнэ.
- **Илтгэх:** Төслийн үндэсний зохицуулагч нь дараах тайлан илтгэлүүдийг НҮБХХ-д бэлтгэн өгөх үүрэг хүлээнэ. Үүнд: Улирлын байдлын тайлан, Жилийн үйл ажиллагааны тайлан \ЖАТ\ ба Төслийн эцсийн тайлан орно.
- **Мэдээлэл солилцох:** Төслийн баг үйл ажиллагааны туршлага дээрээ үндэслэн цаашид хэрэгжих ижил төстэй төслүүдийн үйл ажиллагаанд хэрэгтэй байж болох мэдээ материалыг боловсруулан тайлан бэлтгэж НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газарт өгнө. Мөн шаардлагатай бол төслийн баг төсөлтэй холбоотой техникийн тайлан мэдээг боловсруулна. Энэхүү тайланд тодорхой салбар, орон нутагт оруулсан төслийн хувь нэмрийн талаар өгүүлэх ба олон улсын, үндэсний болон орон нутгийн түвшинд холбогдох мэдээлэл, тэргүүн туршлагыг түгээх ажилд ашиглана.

4.2 Санхүүгийн хяналт шалгалт

Бүх түвшинд хийгдэх янз бүрийн хяналтын механизмаар дамжуулан төслийн санхүүгийн нөөцийн ашиглалт, зарцуулалтыг зохицуулна. Санхүүгийн бүх гүйлгээг НҮБХХ-т шинээр нэвтрүүлсэн АТЛАС байгууллагын нөөцийн төлөвлөлтийн систем ашиглан хянаж, бүртгэн, дүн шинжилгээ хийгээд илтгэнэ.

Төсөл хэрэгжүүлэх нэгж нь НҮБХХ-ийн холбогдох багийн хяналтын дор үйл ажиллагаагаа явуулна. Энэхүү баг нь төслийн үйл ажиллагаа хөтөлбөр, төлөвлөгөөнийхөө дагуу явагдаж, нөөцийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, баталгаажуулна. НҮБХХ-ийн санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Зарлагыг зохих ёсоор нь үнэн зөв зарцуулсан эсэхийг баталгаажуулахын тулд санхүүгийн тайлан мэдээг төсвийн төлөвлөгөөтэй харьцуулан хянана
- Холбогдох нотлох баримт бичгүүд болон зарлагын нарийвчилсан мэдээллийг хянан шалгах замаар санхүүгийн мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэхийг нотлон баталгаажуулна
- Зарлагын үнэн бодит болохыг нотолж, баталгаажуулахад шаардлагатай тодруулга, нэмэлт мэдээлэл хүсэж болно
- Төслийн санхүүгийн менежментийг НҮБХХ-ийн стандарт, нормод нийцүүлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаар төсөл хэрэгжүүлэгч нэгжид зөвлөгөө, техникийн туслалцаа үзүүлнэ
- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зарцуулсан Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөнд нийцээгүй эсвэл хангалттай хэмжээний нотлох мэдээлэл, баримт бичиггүй зардлыг НҮБХХ-өөс нөхөн олгохгүй байж болно.

Аудит, дүн шинжилгээ

НҮБХХ-ийн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн дүрэм, журмын дагуу төсөлд аудит хийдэг. Үүнээс гадна, төсөл хэрэгжүүлэх хугацаанд дор хаяж нэг удаа Монгол улсын Засгийн газар, НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар болон Люксембургийн Засгийн газар төслийн талаар гурван талын уулзалт хийнэ.

Холбогдох талуудын эрх ашгийн үүднээс НҮБХХ дараах тусгай механизмуудыг тодорхой болгон хэрэгжүүлнэ: Жилийн үйл ажиллагааны тайланг гаргаж Люксембургийн засгийн газар, холбогдох талуудыг төлөөлсөн Удирдах зөвлөл болон Гурван талын уулзалтад дарааллан тус бүр төсөл хэрэгжих хугацаанд дор хаяж нэг удаа танилцуулахаас гадна хөндлөнгийн эцсийн үнэлгээнд оруулна.

Гурван талын эцсийн уулзалт хурлыг төсөл хэрэгжих сүүлийн жил зохион байгуулна. ОБЕГ буюу Төслийн үндэсний захирал нь эцсийн тайланг хариуцан гаргаж НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар ба Люксембургийн Засгийн газарт өгч нийтэд хүргэнэ. Энэхүү тайланг эхний байдлаар Удирдах зөвлөлийн эцсийн уулзалт хурал болохоос наад зах нь 6 сарын өмнө бэлэн болгож Удирдах зөвлөлд хүргүүлж тайлантай танилцах боломж олгох ба ингэснээр уулзалтаар тайланг хэлэлцэх боломжтой болно.

Төслийг дор хаяж нэг удаа (хоёр байх нь ховор) хөндлөнгийн үнэлгээнд оруулна. Хөндлөнгийн эцсийн үнэлгээг сүүлийн Удирдах зөвлөлийн хуралдаанаас гурван сарын өмнө хийлгэнэ.

Хавсралт-1: Төслийн үр дүн

<p>2012-2016 онд хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр үзүүлэх НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд нэн тэргүүнд хэрэгжүүлэхээр тусгасан ажлууд</p> <p>НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд тусгасан үр дүн: Үндэсний ба орон нутгийн түвшинд байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн гамшгийн эрсдэл, сөрөг үр дагавар багасна.</p> <p>2012-2016 онд хэрэгжүүлэх Үндэсний төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үр дүн, зорилтууд: уур амьсгалын ба гамшгийн эрсдлийн менежментийн зохицуулалт, харилцаа холбооны чадавхи сайжирсан байна.</p> <p>Зорилтууд:</p> <ul style="list-style-type: none"> - Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын чиг үүрэг, оролцоо тодорхой болно. - Онцгой байдлын асуудал эрхэлсэн гол байгууллагуудын байгалийн ба хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн гамшигтай тэмцэх хүний нөөцийн болон техникийн чадавхи бэхжинэ. - Уур амьсгал, цаг агаарын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрт зарлан мэдээлэх системийн ажиглах, илрүүлэх болон урьдчилан мэдэх чадавхи нэмэгдэнэ. - Хот ба хөдөөгийн нөхцөлд тохирсон олон нийтэд түшиглэсэн уур амьсгалын ба гамшгийн эрсдлийн менежментийн ялгаатай үйл ажиллагаанууд сайжирна. 				
Хүлээгдэж буй үр дүн ба өнөөгийн байдал	Төслийн үйл ажиллагааны зорилтууд /жил тус бүрээр/	Хэрэгжих үйл ажиллагаа	Үр дүнгийн үзүүлэлт	Түнш байгууллагууд
<p>1-р үр дүн. Бодлого, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой болж гамшгийн эрсдлийн менежмент сайжирна.</p> <p>Өнөөгийн байдал: Орон нутгийн гамшгаас хамгаалах байгууллагуудын чиг үүрэг, санхүүжилтийн механизм тодорхойгүй . Аймаг, дүүргүүдийн онцгой байдлын газар, хэлтсүүд хоорондын зохицуулалт хангалтгүй</p>	<p>2013 оны зорилт: Төвийн² болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын³ гамшгийн эрсдлийн менежментийн хүрээнд гүйцэтгэх үүргийг бодитой, тогтвортой болгоно Албан ёсны баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулж орон нутгийн гамшгийн менежментийн үр дүнтэй механизмыг бий болгон, жендерийн асуудлыг тусгана.</p> <p>2013-2014 оны зорилт: Гамшгаас хамгаалах тухай хуулинд шаардлагатай засвар өөрчлөлтийг албан ёсоор тусгана.</p>	<p>1.1 Одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн, байгууллагын болон бодлогын шинжтэй хөтөлбөрүүдийг хянан үзэж, гамшгийн эрсдлийн менежменттэй холбоотой үүрэг хариуцлагыг тодорхой болгоно.</p>	<p>Төв, орон нутгийн удирдлага болон бусад холбогдох байгууллагуудын гамшгийн менежментийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлагын талаар боловсруулсан бодлогын санал, зөвлөмжүүд</p> <p>Үндэсний түвшний холбогдох байгууллагуудтай хийсэн хэлэлцүүлэгт үндэслэн боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө</p>	<p>Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагууд Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, орон нутгийн удирдлага ба иргэний байгууллагууд ТББ-ууд</p>

² ОБЕГ болон бусад Гамшгийн эрсдлийн менежмент хариуцсан яам, хэлтсүүд

³ Гамшгийн эрсдлийг бууруулах түншлэлийн зөвлөл, малчдын бүлэг, өөртөө туслах бүлгүүд

		<p>1.2 Олон улсын тэргүүн туршлагад үндэслэн орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах менежментийн үйл ажиллагааны санхүүжилт, зохицуулалт, менежментийн тохиромжтой механизмыг бий болгоно.</p>	<p>Орон нутгийн үр дүнтэй механизмыг бүтэц, зохион байгуулалтад оруулахыг зөвлөсөн тайлан илтгэл ба холбогдох талуудын оролцоотой боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө:</p> <ul style="list-style-type: none"> - Гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны зохицуулалтын төлөвлөгөө - Төсвийн хуваарилалтын механизмд гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тусгах тухай зөвлөмж - Гамшгийн эрсдлийн системийг боловсронгуй болгох зохицуулалт, дүрэм журам, 	
		<p>1.3 Орон нутгийн түвшинд /дүүрэг, хороо, аймаг, сум/ гамшгийн удирдлагын үйл ажиллагааны механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Бодлогын зөвлөмж, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулсан байна:</p> <ul style="list-style-type: none"> - Шинэ механизм, түүнтэй холбогдох арга туршлагыг ашиглахад шийдвэр гаргагчдыг сургасан сургалтууд - Санал болгосон механизмын талаар олон нийтийн хэлэлцүүлгүүд <p>Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийн менежментийг дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ</p>	

<p>2-р үр дүн. Орон нутгийн гамшгийн менежментийн механизм хот ба хөдөөгийн эмзэг байдлын шинж чанарт зохицсон чадавхи, үйл ажиллагаатай болно</p> <p>Өнөөгийн байдал: Орон нутгийн түвшинд гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах ажиллагаанд шаардлагатай хүний, техникийн болон санхүүгийн чадавхи сул.</p> <p>Сум, багийн түвшинд гамшгийн менежментийн үйл ажиллагаа хариуцсан албан ёсны алба, хэлтэс байхгүй.</p>	<p>2014 оны зорилт: Чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж хэрэгжүүлнэ. Байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, зохицуулалтыг сайжруулах замаар бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах ажиллагааны нэгдмэл байдал, уялдаа холбоог нэмэгдүүлнэ</p> <p>Үндэсний, бүс нутгийн, аймгийн, сумын түвшинд болон орон нутгийн өөртөө туслах бүлгэмүүдэд төсөв хуваарилахдаа гамшгийн эрсдлийн менежментийн үзүүлэлтүүдийг ашиглаж туршина</p> <p>Нөөцийн дайчилгаа болон бараа материалын худалдан авалтын төлөвлөгөөг аймаг, сумын онцгой байдлын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ Хүйсийн харьцааг харгалзан боловсруулсан янз бүрийн аюул осол, эмзэг байдал, иргэдийн авах хариу арга хэмжээний талаар олон нийтэд мэдлэг олгох материалыг Засгийн газар эзэмшиж, түгээх ажлыг хариуцна</p>	<p>2.1 Янз бүрийн арга хэлбэр ашиглан аюул, эмзэг байдал ба иргэдийн авах хариу арга хэмжээний талаар олон нийтийн мэдлэг, сонор сэрэмжийг дээшлүүлнэ</p>	<p>Гамшгийн мэдлэг, сонор сэрэмж дээшилсэн тухай судалгааны тайлангууд</p> <p>Сургалтын материалуудыг боловсруулж, тараана</p> <p>Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсөл хөтөлбөрийг түгээнэ Явуулын гэр мэдээллийн төвүүдээс мэдээлэл авсан хүмүүсийн өсөлтийн хувь</p>	<p>Төв ба орон нутгийн онцгой байдлын газар, Үндэсний байгаль орчны хяналт шинжилгээний агентлаг, Үндэсний болон орон нутгийн мэдээллийн хэрэгсэл, орон нутгийн засаг захиргаа (Улаанбаатар хотын захиргааг оруулан), нутгийн иргэдийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил</p>
		<p>2.2 Орон нутгийн гамшгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг онцгой байдлын байгууллагуудын чадавхийг бэхжүүлнэ.</p>	<p>Аймаг, дүүргийн онцгой байдлын байгууллагууд, гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөл болон иргэдийн чадавхийг сайжруулах зөвлөмж бүхий чадавхийн үнэлгээний тайлан Орчин үеийн мэдлэг чадварыг эзэмшсэн аврагчид Гамшгийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж, мэдээлэл солилцох боломж олгох аргачлал, програмууд</p>	

	<p>2015 оны зорилт: Хотын дүүрэг, аймаг, сумдад гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн баг, ажлын хэсгүүд гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд сайн дурынхны дэмжлэг туслалцааг авна</p> <p>2016 оны зорилт: Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого болон Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан нэн тэргүүний ажлуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>		<p>Хот, дүүрэг, аймаг болон сумын түвшинд хийсэн эмзэг байдал, аюулын зураглалын тоо Онцгой байдлын байгууллага, ажлын хэсгүүдэд сайн дураар бүртгүүлсэн иргэдийн тоо Аймаг, дүүргийн онцгой байдлын байгууллагууд болон өөртөө туслах бүлгүүд, ажлын хэсгүүдийн авсан бараа материалын хэмжээ</p>	
		<p>2.3 Гамшгийн менежментийн ажлын хэсгүүд байгуулан хор уршгийг арилгах янз бүрийн ажиллагаанд жишээ нь эрт зарлан мэдээллэх систем, эрэн хайх, аврах ажиллагаа, анхны тусламж үзүүлэх, хоргодох байрны менежмент, сэтгэлзүйн зөвлөгөө ба хохирлын үнэлгээ гаргах зэрэгт сургана</p>	<p>Боловсруулан, хэвлэж тараасан сургалтын гарын авлага, материалын тоо хэмжээ Батлуулсан аюулгүй байдлын стандартын тоо Байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж буй ажлын хэсгүүдийн тоо Янз бүрийн аюулын үеийн үйл ажиллагааны стандарт, арга барилыг эзэмшсэн иргэд, сайн дурынхны тоо Аймаг, сумын түвшинд гамшгийн эрсдлийг тодорхойлох системийг туршина</p>	
		<p>2.4 Аюул, эмзэг байдал, цаг агаарын урьдчилсан мэдээг эрт зарлан мэдээллэх, түгээх механизмыг бэхжүүлнэ</p>	<p>Цаг уур, орчны шинжилгээний газартай холбогдсон өртөг багатай эрт зарлан мэдээллэх системийн загвар гаргана</p>	

<p>3-р үр дүн. Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, хор уршгийг арилгах үр дүнтэй механизм улам сайжран бэхжинэ</p> <p>Өнөөгийн байдал: Орон нутгийн түвшинд гамшгийн менежментийн үр дүнтэй механизмыг орон нутгийн засаг захиргааны бүтцэд уялдуулан нэгтгээгүй байна.</p> <p>Гамшгийн эрсдлийг бууруулах ажиллагаанд салбар хоорондын үйл ажиллагааны зохицуулалт нягт хамтын ажиллагаа ямар ач холбогдолтой болохыг шийдвэр гаргах түвшинд сайн ойлгохгүй байна.</p>	<p>2014 оны зорилт: Аймаг, сумын удирдлагууд, орон нутгийн иргэдийн гамшгийн мэдлэгийг дээшлүүлж, гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааг бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтөд уялдуулан нэгтгэхийн ач холбогдлыг ойлгуулна</p> <p>Жендерийн асуудлыг тусгасан гамшгийн эрсдлийн менежментийн төлөвлөгөө боловсруулна. (үүнд Улаанбаатар хотын дүүрэг, сум, аймгийн засаг захиргааны түвшинд хэрэгжүүлэн туршсан зохицуулалтын, хор уршгийг бууруулах болон арилгах, бэлэн байдлыг хангах үр дүнтэй арга хэлбэрүүдийг тусгана)</p> <p>Аймаг, сумын хөдөө аж ахуйн болон усны аж ахуйн салбарын төлөвлөгөөнд гамшгийн эрсдлийг бууруулах практик аргуудыг тусгана</p>	<p>3.1 Хот, хөдөөгийн нөхцөлд тохирсон, орон нутгийн болон бүс нутгийн онцлогийг харгалзсан гамшгийн менежментийн механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Аймгийн Онцгой байдлын хэлтэс болон орон нутгийн өөртөө туслах бүлгүүдийн хооронд харилцан үүрэг хариуцлагаа тусгаж байгуулсан Харилцан ойлголцлын санаамж бичгийн тоо Орон нутгийн гамшгийн менежментийн талаарх мэдлэг, ойлголт нь сайжирсан холбогдох бүлгүүдийн тоо</p> <p>Малчдын бүлэг болон өөртөө туслах бүлгийн зохицуулагчаар ажилласан тухайн улс дахь НҮБ-ын сайн дурынхны тоо</p>	<p>Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн байгууллага Улаанбаатар хотын захиргаа, гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөл, Аймаг, дүүргийн онцгой байдлын газар, хэлтсүүд</p>
	<p>2015-2016 оны зорилт: Аймаг, сумын түвшинд гамшгийн эрсдлийн менежментийн чиглэлээр тодорхой хууль эрх зүй, техникийн болон санхүүгийн орчинд хэрэгжиж буй үр дүнтэй зохицуулалтын механизмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ</p> <p>Гамшгийн менежментийн үр дүнтэй, оновчтой механизмыг дор хаяж дөрвөн аймагт дахин хэрэгжүүлсэн байна</p>	<p>3.2 Орон нутгийн түвшинд жендерийн асуудлыг тусгасан гамшгийн менежментийн төлөвлөгөө боловсруулж орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулан нэгтгэнэ. Уг төлөвлөгөөнд янз бүрийн аюулын бэлэн байдлыг хангах, хор уршгийг бууруулах болон арилгах ажиллагааны асуудлыг тусгасан байна.</p>	<p>Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн үйл явцад уялдуулах заавар, журам Үндэсний, хотын, дүүргийн, аймгийн болон сумын түвшинд боловсруулан хэрэгжүүлдэг олон төрлийн гамшгийн аюулд бэлэн байдлыг хангах, хор уршгийг бууруулах төлөвлөгөөнд жендерийн асуудлыг тусгасан байдал, уг асуудлыг тусгасан төлөвлөгөөний тоо Аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичигт тусгагдсан нутгийн иргэдийн гамшгийн эмзэг байдлыг бууруулах нэн тэргүүний асуудалд чиглэсэн үйл ажиллагааны тоо</p>	
		<p>3.3. Сайн дурынхны дэмжлэгтэйгээр (сайн дурынхан, өөртөө туслах бүлгүүд, түншлэлийн зөвлөл, эрт зарлан мэдээлэх систем, гал унтраах анги гэх мэт) орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр амжилттай хэрэгжсэн туршлагыг дахин хэрэгжүүлнэ</p>	<p>Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр туршин хэрэгжүүлж, амжилттай болох нь нотлогдсон арга, туршлагатай аймаг, сумын тоо</p> <p>Өөртөө туслах бүлгийн тоо Түншлэлийн зөвлөлийн тоо Явуулын гэр мэдээллийн төвийн тоо Гал унтраах ангийн тоо Эрт зарлан мэдээлэх системийн тоо</p>	

Хавсралт 2. Төсөв ба ажлын төлөвлөгөө

Үр дүн	Үйл ажиллагаа	Хандивлагч	Тайлбар	Жилийн дүн ам. дол				Нийт дүн	
				2012	2013	2014	2015		
1-р үр дүн: Бодлого, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой болж гамшгийн эрсдлийн менежмент сайжирна.	1.1. Одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн, байгууллагын болон бодлогын шинжтэй хөтөлбөрүүдийг хянан үзэж, гамшгийн эрсдлийн менежменттэй холбоотой үүрэг хариуцлагыг тодорхой болгоно.	ЛЗГ	Үндэсний зөвлөх	4000	6000			10000	
			Үйлчилгээний контракт	10000	8000			18000	
		НҮБХХ	Гадаадын зөвлөх	35000	30000			65000	
	1.2. Олон улсын тэргүүн туршлагад үндэслэн орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах менежментийн үйл ажиллагааны санхүүжилт, зохицуулалт, менежментийн тохиромжтой механизмыг бий болгоно.	ЛЗГ	Гадаадын зөвлөх		20000			20000	
			Гадаадын зөвлөх	4000	6000			10000	
			Сургалт семинар	4000	8000			12000	
	1.3 Орон нутгийн түвшинд /дүүрэг, хороо, аймаг, сум/ гамшгийн удирдлагын үйл ажиллагааны механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	ЛЗГ	Үндэсний зөвлөх	2000	6000	6000		14000	
			Сургалт семинар		10000	5000		15000	
			Дуу дүрс бичлэгийн/хэвлэх		3000			3000	
			Аялал	5000	5000			10000	
			Бусад	1000	1000	1000		3000	
	Хэсгийн дүн \ЛЗГ\				30000	73000	12000	0	115000
	Хэсгийн дүн \НҮБХХ\				35000	30000	0	0	65000

Үр дүн	Үйл ажиллагаа	Хандивлагч	Тодорхойлолт	Жилийн дүн ам. дол				Нийт дүн	
				2013	2014	2015	2016		
1-р үр дүн: Бодлого, зохицуулалтын орчинг бүрдүүлснээр талуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага тодорхой болж гамшгийн эрсдлийн менежмент сайжирна.	1.1. Одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн, байгууллагын болон бодлогын шинжтэй хөтөлбөрүүдийг хянан үзэж, гамшгийн эрсдлийн менежменттэй холбоотой үүрэг хариуцлагыг тодорхой болгоно.	ЛЗГ	Үндэсний зөвлөх	4,000	6,000			10,000	
			Гэрээт ажил	10,000	8,000			18,000	
	1.2. Олон улсын тэргүүн туршлагад үндэслэн орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах менежментийн үйл ажиллагааны санхүүжилт, зохицуулалт, менежментийн тохиромжтой механизмыг бий болгоно.	ЛЗГ	НҮБХХ	Сургалт/семинар	15,000	15,000			30,000
				Олон улсын зөвлөх	10,000	10,000			20,000
	1.3 Орон нутгийн түвшинд /дүүрэг, хороо, аймаг, сум/ гамшгийн удирдлагын үйл ажиллагааны механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	ЛЗГ		Үндэсний зөвлөх	4,000	6,000			10,000
				Сургалт/семинар	4,000	8,000			12,000
				Үндэсний зөвлөх	6,000	6,000	2,000		14,000
				Сургалт/семинар	10,000	5,000	0		15,000
				Дуу дүрс бичлэгийн/хэвлэмэл		3,000			3,000
	Хэсгийн дүн \ЛЗГ\				54,000	58,000	3,000	0	115,000
Хэсгийн дүн \НҮБХХ\				15,000	15,000	0	0	30,000	
2-р үр дүн. Орон нутгийн гамшгийн менежментийн механизм хот ба хөдөөгийн эмзэг байдлын шинж чанарт зохицсон чадавхи, үйл ажиллагаатай болно	2.1 Янз бүрийн арга хэлбэр ашиглан аюул, эмзэг байдал ба иргэдийн авах хариу арга хэмжээний талаар олон нийтийн мэдлэг, сонор сэрэмжийг дээшлүүлнэ	ЛЗГ	Үндэсний зөвлөх	2,000	5,000	5,000	5,000	17,000	
			Сургалт/семинар	10,000	10,000	10,000	8,000	38,000	
			Дуу дүрс бичлэгийн/хэвлэмэл	5,000	10,000	10,000	5,000	30,000	
			Гэрээт ажил		10,000	10,000		20,000	
			Түрээс		2,000	2,500	2,500	7,000	

	2.2 Орон нутгийн гамшгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлдэг онцгой байдлын байгууллагуудын чадавхийг бэхжүүлнэ.	ЛЗГ	Үндэсний зөвлөх	8,000	16,000	15,000	5,000	44,000
			Гэрээт ажил		20,000	20,000	10,000	50,000
			Тоног төхөөрөмж	80,000	10,000			90,000
			Сургалт/семинар		20,000	20,000	7,000	47,000
			Бараа, үйлчилгээ		5,000	5,000	3,000	13,000
	2.3 Гамшгийн менежментийн ажлын хэсгүүд байгуулан хор уршгийг арилгах янз бүрийн ажиллагаанд жишээ нь эрт зарлан мэдээллэх систем, эрэн хайх, аврах ажиллагаа, анхны тусламж үзүүлэх, хоргодох байрны менежмент, сэтгэлзүйн зөвлөгөө ба хохирлын үнэлгээ гаргах зэрэгт сургана	ЛЗГ	Олон улсын зөвлөх		18,000	0	0	18,000
			Үндэсний зөвлөх	2,000	12,000	13,500	15,000	42,500
			Гэрээт ажил		20,000	20,000	0	40,000
			Сургалт		15,000	20,000	5,000	40,000
			Аялал		8,000	8,000	5,000	21,000
			Бараа, үйлчилгээ	1,000	2,000	2,000	1,000	6,000
	2.4 Аюул, эмзэг байдал, цаг агаарын урьдчилсан мэдээг эрт зарлан мэдээллэх, түгээх механизмыг бэхжүүлнэ	ЛЗГ	Гэрээт ажил		15,000			15,000
			Үндэсний зөвлөх	2,000	5,000			7,000
			Сургалт/аялал		6,000			6,000
			Бараа, материал		10,000	3,000		13,000
Хэсгийн дүн ҮЛЗГ				111,000	220,000	165,000	72,500	568,500
3-р үр дүн. Орон нутгийн гамшгийн эрсдлийг бууруулах, хор уршгийг арилгах үр дүнтэй механизм улам сайжран бэхжинэ	3.1 Хот, хөдөөгийн нөхцөлд тохирсон, орон нутгийн болон бүс нутгийн онцлогийг харгалзсан гамшгийн менежментийн механизмыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	ЛЗГ	Үндэсний зөвлөх		8,000	8,000	8,000	24,000
			Гэрээт ажил		10,000	10,000		20,000
			Сургалт		8,000	8,000		16,000
			Аялал		4,000	4,000		8,000
	3.2 Орон нутгийн түвшинд жендерийн асуудлыг тусгасан гамшгийн менежментийн төлөвлөгөө боловсруулж орон нутгийн хөгжлийн бодлогод уялдуулан нэгтгэнэ. Уг	ЛЗГ	Гэрээт ажил		15,000			15,000
			Сургалт		7,000	5,000		12,000
			Аялал		4,000	4,000		8,000
			Дуу дүрс бичлэгийн/хэвлэмэл		5,000	3,000		8,000

	төлөвлөгөөнд янз бүрийн аюулын бэлэн байдлыг хангах, хор уршгийг бууруулах болон арилгах ажиллагааны асуудлыг тусгасан байна.							
	3.3. Сайн дурынхны дэмжлэгтэйгээр (сайн дурынхан, өөртөө туслах бүлгүүд, түншлэлийн зөвлөл, эрт зарлан мэдээллэх систем, гал унтраах анги гэх мэт) орон нутагт гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр амжилттай хэрэгжсэн туршлагыг дахин хэрэгжүүлнэ	ЛЗГ	Үндэсний зөвлөх		18,000	18,000	10,000	46,000
			Гэрээт ажил		20,000	15,000		35,000
			Сургалт		8,000	8,000	5,000	21,000
			Тоног төхөөрөмж		30,000	30,000		60,000
			Аялал		8,500	7,500	3,000	19,000
			Бусад		1,500	1,500	1,500	4,500
Хэсгийн дүн \ЛЗГ\				0	147,000	122,000	27,500	296,500
Төслийн үйл ажиллагааны менежмент, хяналт	Дунд хугацааны болон эцсийн үнэлгээ	ЛЗГ	Олон улсын зөвлөх	0	0	0	23,000	23,000
			Үндэсний зөвлөх	0	12,000	0	7,000	19,000
	Менежмент	ЛЗГ	Хүний нөөц	31,000	42,000	42,000	42,000	157,000
			Тоног төхөөрөмж	10,000	2,000	2,000	1,700	15,700
			Аялал	2,000	5,000	5,000	5,000	17,000
			Түрээс	1,000	3,000	3,000	3,000	10,000
			Бараа, материал	5,000	7,000	7,000	7,000	26,000
			Бусад	2,000	5,000	5,000	5,000	17,000
	НҮБХХ	Хүний нөөц	13,000	17,000	17,000	17,000	64,000	
		Бараа, материал	1,000	2,000	2,000	1,000	6,000	
Хэсгийн дүн \ЛЗГ\				51,000	76,000	64,000	93,700	284,700
Хэсгийн дүн \НҮБХХ\				14,000	19,000	19,000	18,000	70,000
Дүн (Люксембург)				216,000	501,000	354,000	193,700	1,264,700
Ерөнхий удирдлагын зардал (GMS) (7%)				15,120	35,070	24,780	13,559	88,529
Дүн (НҮБХХ)				29,000	34,000	19,000	18,000	100,000
Дүн				260,120	570,070	397,780	225,259	1,453,229
Дотоод дэмжлэг үйлчилгээний зардал (ISS) (НҮБХХ ~3%)				6,000	18,000	16,500	6,271	46,771

НИЙТ ДҮН	266,120	588,070	414,280	231,530	1,500,000
-----------------	----------------	----------------	----------------	----------------	------------------

Хавсралт 3. Эрсдлийн бүртгэл

№	Төрөл	Ажил	Тодорхойлолт	Тайлбар	Одоогийн байдал	Хариуцагч
1	Санхүүгийн	Хөтөлбөр боловсруулах	Хөрөнгийн хэмжээ тохиромжгүй байх, зориулалтын дагуу, зохих ёсоор ашиглагдахгүй байх эрсдэл	Төсөл хэрэгжүүлэх явцад зарцуулсан хөрөнгөд Санхүүгийн шалгалт хийх систем бий болгох. Биет тооллого болон санхүүгийн явцын тайлан илтгэл гаргах	Хяналтын систем сонгон ашиглахдаа энэ асуудлыг харгалзан үзнэ	Төсөл хэрэгжүүлэгч нэгж, НҮБХХ
2	Байгууллагын	Хөтөлбөр боловсруулах	НҮБХХ, түүний түншүүдийн чадавхи хязгаарлагдмал байгаа нь төслийн хэрэгжилтэд саад болж байна	НҮБХХ-ийн төлөөлөгчийн газарт үндэсний мэргэжилтэн авч ажиллуулах замаар дотоод чадавхийг нь нэмэгдүүлэх, үндэсний хэмжээнд хамтран ажиллагсдад системтэйгээр чадавхиа бэхжүүлэх боломж олгох, хяналт, үнэлгээний хүрээг нэгд нэгэнгүй мөрдөн ажиллах	Хөтөлбөр боловсруулахдаа энэ асуудлыг харгалзан үзнэ	НҮБХХ, Зардал гүйцэтгэлийн хяналтын зөвлөл
3	Байгууллагын	Хөтөлбөр боловсруулах	Зохицуулалтын механизм сул, үр дүнгүй байгаа нь нэг ажлыг давхар хийх, хамтран илүү үр бүтээлтэй ажиллах боломжийг алдах нөхцөл бүрдүүлж байна	ОБЕГ-т төслийн холбогдох талуудтай тогтмол уулзах замаар зохицуулалтын механизмыг бэхжүүлэх. Хамтын ажиллагаагаа бэхжүүлж, ажил давхардуулан хийхгүйн тулд орон нутгийн удирдлага, онцгой байдлын газрууд, гамшгийн эрсдлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны зөвлөл болон ижил төстэй зорилго бүхий бусад төслийн багтай тогтмол уулзах. Засгийн газар, төрийн бус байгууллагууд болон гадны түншүүдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй үйл ажиллагаагаа уялдуулан үр бүтээмжээ нэмэгдүүлэхэд анхаарах	Хөтөлбөр боловсруулахдаа энэ асуудлыг харгалзан үзэх ба тогтмол уулзалт хурал зохион байгуулах замаар хяналт тавина	ОБЕГ, Төсөл хэрэгжүүлэгч нэгж, НҮБХХ
4	Гадаад	Хөтөлбөр боловсруулах	Байгалийн гамшиг \зуд, ган, ойн түймэр, үер\ давтагдах нь шинээр хор хохирол учруулж сэргээн босгох үйл ажиллагааг	Байгалийн гамшиг давтагдах нь чадавхийг бэхжүүлэх үйл явцыг удаашруулна. Иймээс орон нутгийн удирдлага болон эдгээр аюулын эрсдэлд өртөх өндөр эрсдэлтэй иргэдийг чадавхижуулахад онцгой анхаарч, эрт зарлан мэдээллэх систем болон гамшгийн бэлэн байдлыг хангах хөтөлбөрийг эрчимжүүлэх замаар гамшиг давтагдахаас сэргийлнэ.	Хөтөлбөр боловсруулахдаа энэ асуудлыг харгалзан үзнэ	ОБЕГ, НҮБХХ-ийн ХССТ, ОНТГМН, Сумын ГЭБТЗ

			удаашруулна			
--	--	--	-------------	--	--	--

Хавсралт 4. Удирдах зөвлөлийн ажлын удирдамж

Удирдах зөвлөл нь техникийн зөвлөгөө өгөх, менежментийн удирдлагаар хангах болон төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, баталгаажуулах эрх үүрэгтэй байна. Төслийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах ажлыг Төслийн зохицуулагч хариуцна. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдох нь нэр төрийн хэрэг бөгөөд үүнийхээ төлөө аливаа цалин урамшуулал авахгүй болно.

Удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

1. Шадар сайд /Шадар сайдын томилсон ОБЕГ-ын дарга – *Удирдах зөвлөлийн дарга байна*
2. ОБЕГ
3. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам /ойн болон аюултай материалын хэлтсээс/
4. НҮБХХ / төсөл хариуцсан ажилтан/ - төслийн хэрэгжилт хариуцна
5. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам /мал аж ахуй, бэлчээрийн асуудал эрхэлсэн хэлтэс/
6. Барилга, хот байгуулалтын яам /барилгын аюулгүй байдал, стандарт, норм, норматив/
7. Улсын мэргэжлийн хяналтын газар
8. Ус цаг уур, орчны шинжилгээний газар
9. Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газар
10. Баруун/зүүн бүсийн сумын засаг захиргааны төлөөлөл
11. Өмнөд/төвийн бүсийн сумын засаг захиргааны төлөөлөл

Удирдах зөвлөл нь зургаан сар тутам хуралдах ба шаардлагатай бол илүү ойр хугацаанд хуралдаж төслийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэнэ.

Удирдах зөвлөл нь дараах ажлуудыг хариуцна:

- Төслийг удирдамж, чиглэлээр хангаж, түүний үйл ажиллагаа тогтоосон хязгаарт явагдаж байгаа эсэхийг баталгаажуулна
- Төслийн удирдагчийн төслийн үйл ажиллагааг удирдан явуулж, үр дүнд хүрч буй арга барилыг хүлээн зөвшөөрнө
- Төслийн тайланг хянаж батална, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргана
- Төслийн зохицуулагчийн эрх хэмжээнээс давсан нөхцөл байдал үүсэхэд тохирох заавар, зөвлөмжөөр хангана
- Төсөлд оруулах өөрчлөлтийг үнэлэн дүгнэж, эцсийн шийдвэр гаргана
- Төлөвлөсөн үйл ажиллагааг хангалттай түвшинд гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж, баталгаажуулна
- Төслийн үйл ажиллагаа үр дүнтэй, амжилттай, цаг хугацаандаа хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавина
- Төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар чиглэл өгөх ба хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь тухайн улсад тулгамдаж буй нэн тэргүүний асуудлуудыг шийдэх явдлыг баталгаажуулна
- Төслийн үйл ажиллагаа нь төслийн баримт бичиг, НҮБХХ-ийн санхүүгийн дүрэм журам, зохицуулалт, төсөл санхүүжүүлэгч, хандивлагчдын шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавьж баталгаажуулна
- Төслийн үйл ажиллагааг нэгдмэл, цогц байдлаар хэрэгжүүлэх үүднээс форум зохион байгуулж холбогдох байгууллагуудад санал бодлоо солилцож, харилцан туршлага солилцох боломж олгоно
- Төсөл хэрэгжүүлэгч нэгж бие даан шийдэж чадахгүй байгаа төслийн үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа зөрчил, маргаантай асуудлыг шийдвэрлэнэ

- Холбогдох байгууллагуудад хариуцсан төслийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ
- Төслийн жилийн тайлан, ажлын төлөвлөгөө болон үйл ажиллагааны төсвийг хянан үзэж, төлөвлөсөн өөрчлөлтийн талаар санал, зөвлөмж өгнө
- Гурван талын уулзалт хуралд оролцож шаардлагатай үед төслийн баримт бичигт стратегийн өөрчлөлт оруулахыг санал болгож болно

Төслийн хэрэгжилтийн хугацаа дуусах үед:

- Төслийн бүх үйл ажиллагаа хангалттай түвшинд хэрэгжсэн эсэхийг баталгаажуулна
- Төслийн үйл ажиллагааг дүгнэсэн хөндлөнгийн тайлантай танилцаж, төслийн эцсийн тайланг батална
- Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон төслийн хэрэгжилтийг хянах төлөвлөгөөний талаар зөвлөмж гаргана
- Төсөл дууссан талаар Үр дүнгийн зөвлөлд мэдэгдэнэ

Хавсралт 5: Төслийн үндэсний захирлын ажлын удирдамж

Хариуцах асуудал ба чиг үүрэг:

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газрыг НҮБХХ-ийн дэмжлэг бүхий “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийн бууруулах, удирдлага зохицуулалтын чадавхийг сайжруулах нь” төслийг үндэсний хэмжээнд хариуцан хэрэгжүүлэхээр томилсон.

1. Төслийг хариуцан хэрэгжүүлэх агентлагаас томилсон Төслийн үндэсний захирал нь төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Засгийн газрын төлөөлөл байх ба төслийг хэрэгжүүлэгч агентлагийн талаас хариуцах гол албан тушаалтан байна. Мөн түүнчлэн төслийн стратегийн зорилтын хэрэгжилт, үр дүнд хяналт мониторинг хийж, Засгийн газар болон холбогдох бусад байгууллагуудын хоорондох харилцан ажиллагаа, уялдаа холбоог хангана.

2. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон төслийг хэрэгжүүлэгч агентлагтай нягт хамтран ажиллах хүрээнд Төслийн үндэсний захирал нь дараахь үндсэн үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төслийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үндэсний дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бодлогын түвшинд (Их хурал, Засгийн газар, холбогдох яам, агентлагууд болон иргэний нийгэм, хувийн хэвшил болон хандивлагч бусад байгууллагууд) төслийн үйл ажиллагааг сурталчлан таниулна.
- Төслийн хэрэгжилтийг хангах, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын түвшинд хэлэлцэн тохиролцох болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Дотоодын зөвлөх, сургалтын болон бусад мэргэжилтнүүдийн үйлчилгээ авахаар сонгон шалгаруулалт хийхэд төслийн баг бүрэлдэхүүнд үндэсний бодлогод нийцсэн зааварчилгаа өгнө.
- Гадаад харилцааны яам болон холбогдох бусад байгууллагатай зөвлөн санхүүгийн шаардлагатай бэлэн болон бэлэн бус, эсвэл зардал хуваалцсан хөрөнгийг төлбөр хийх хугацаанд улсын төсөвт тусгуулна.
- Холбогдох дүрэм, журмын дагуу Засгийн газрын баталгаажуулалт шаардсан төслийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг Сангийн яамаар хянуулна.
- Төслийн баримт бичигт заагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд төслийн нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглахын тулд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй зөвлөлдөн төслийн жилийн болон улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлахад оролцоно. Төслийн үндэсний захирал нь өдөр тутам хийгдэх төлбөрийг баталгаажуулж болно.
- Төслийн төсвийг хянаж, төслийн хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэлийг батална.
- Төслийн багтай хамтран төслийн үр дүн, амжилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг нягталж, төслийн үйл ажиллагааны жил бүрийн явцын тайлан болон эцсийн шатны тайланг хянана.
- Төслийн зорилго, зорилтын хэрэгжилтийг дүгнэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон төслийн багтай хамтран Төслийн үнэлгээний хорооны хурал, жил бүрийн болон эцсийн шатны гурван талт уулзалт зэрэг мониторингийн уулзалтуудыг зохион байгуулж, төслийн хяналт, үнэлгээний тайланд санал оруулна.
- Төслийн багтай хамтран Төслийн удирдах зөвлөлд төслийн хэрэгжилтийн талаар тогтмол мэдээлнэ.
- Төслийн үндэсний зохицуулагч, захиргаа, санхүүгийн ажилтан болон төслийн багийн бусад ажилтнуудын ажлын бүтээмжийг тогтмол үнэлнэ.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын төрөлжсөн агентлагууд, хандивлагч байгууллагууд болон Засгийн газраас энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бусад төсөл хөтөлбөрүүдтэй нягт уялдаа, холбоотой ажиллана.

Хавсралт 6. Төслийн үндэсний зохицуулагчийн ажлын удирдамж

Зохион байгуулалт

Төслийн үндэсний зохицуулагч нь Төслийн үндэсний захирлын удирдлага дор ажиллах ба төслийн зорилгыг амжилттай биелүүлж, зорилтот үр дүнд хүргэх

ажлыг хариуцна. Төсөл хэрэгжүүлж буй бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, тэднээс дэмжлэг авах нөхцлийг бүрдүүлнэ.

Ажлын байрны тодорхойлолт

Төслийн үндэсний зохицуулагч нь төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ба үүнд хүний нөөцийн асуудал, гэрээт ажлууд, сургалт, тоног төхөөрөмж, захиргааны ажил, санхүүгийн тайлан илтгэл болон Төслийн үндэсний захирлыг төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээллээр хангах ажлууд хамаарна.

Төслийн үндэсний зохицуулагчийн хүлээх үүрэг хариуцлага:

1. Төслийн ажлын төлөвлөгөөний дагуу шаардлагатай техник хэрэгсэл бүхий оффис байгуулж, үйл ажиллагаа явуулна
2. Төслийн ажлын төлөвлөгөөг тогтмол боловсруулан шинэчилж, тэдгээрийг Төслийн үндэсний захирал болон НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газрын Гамшгийн эрсдлийг бууруулах асуудал хариуцсан хэлтэст батлуулахаар танилцуулна. Төслийн баримт бичигт нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцлийг хангах
3. Төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллагуудтай байгуулах гэрээг бэлэн болгон, хэлэлцэж гарын үсэг зурах ажлыг хариуцна
4. Төсөл хамтран хэрэгжүүлэх гадны байгууллагуудын хувьд:
 - a. Үйл ажиллагаагаа төсөл хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний дагуу явуулж, тодорхой үр дүнд хүрч байгаа эсэхийг баталгаажуулна
 - b. Төслийн хүрээнд зорьсон үр дүндээ хүрэх нөхцлийг бүрдүүлэх үүднээс үйл ажиллагаанд нь хяналт тавьж, зохицуулна
5. Хянан хэлэлцэх, үнэлгээ өгөх уулзалт хурал болон хэлэлцүүлгийн үед төслийн үндсэн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж, Төслийн жилийн тайлан болон бусад үнэлгээний тайлан, илтгэлийг бэлдэн Төслийн үндэсний захиралд танилцуулах ажлыг хариуцна
6. Төслийн үндсэн болон гэрээт ажилчдыг оновчтой хугацаанд нь авч ажиллуулж, сургалт, техник хэрэгслээр /төслийн үндсэн нэгж ба бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын аль нь ч худалдан авсан байж болно/ хангана
 - a. Төслийн тодорхой ажлын байранд нэр дэвшигч чадвар, боломжтой гадаадын болон тухайн улсын нэр дэвшигчдийг тодорхой болгоно
 - b. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага болон гэрээт ажилчидтай зөвлөлдсөний үндсэн дээр ажлын удирдамж гаргана
 - c. Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр төслийн багийг сургах сургалтын хөтөлбөр гаргана /сургалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад анхаарна/
 - d. Төсөл хэрэгжүүлэхэд ашиглах тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үзүүлэлтийг тодорхойлж Засгийн газар болон НҮБХХ-ийн холбогдох дүрэм журам, зааврын дагуу худалдан авалт хийнэ
7. Төслийн үндэсний захирлын нэрийн өмнөөс төслийн төсвийг удирдан зарцуулах үүрэг хүлээж дараах ажлуудыг хариуцна:
 - a. Төслийн санхүүжилт хугацаандаа орж, зохих ёсоор зарцуулагдаж байгаа эсэх
 - b. Санхүүгийн тайлан мэдээ, холбогдох баримтуудыг баталгаатай хадгалах
 - c. Шаардлагатай санхүүгийн тайлан мэдээг бэлэн болгох
 - d. Санхүүгийн тайлан, гүйлгээг НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн санхүүгийн дүрэм журам, зохицуулалтад нийцүүлэн хийж, ил тод байдлыг хангах
 - e. Аудитын хяналт шалгалтад ороход үргэлж бэлэн байх

8. Төслийн техникийн болон захиргааны ажилд хяналт тавих ба үүнд төслийн тухайн улсын болон гадаадын ажиллах хүчний ажлыг хянах асуудал бас хамаарна
9. Үндэсний төслийн захирал, төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллага болон НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газарт төслийн хэрэгжилтийн явц болон тулгарсан аливаа бэрхшээлийн талаар цаг алдалгүй, тогтмол мэдээллэнэ
10. Техникийн, санхүүгийн, судалгааны болон шаардлагатай бусад тайлан мэдээг хугацаанд нь бэлэн болгож, танилцуулах ажлыг хариуцна
11. Төслийн баримт бичигт заасны дагуу төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтын ажлыг хариуцна

Төслийн хэрэгжилтийг дуусгах, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хүлээх үүрэг хариуцлага

Төслийг үр дүнтэй хэрэгжүүлж дуусгахад Төслийн үндэсний зохицуулагчийн гүйцэтгэх үүрэг:

1. Төслийн хугацаа дуусахаас дор хаяж 12 долоо хоногийн өмнө гурван талт эцсийн уулзалтаар /Удирдах зөвлөлийн уулзалт хурал/ хэлэлцэх Эцсийн тайланг боловсруулж бэлэн болгоод хуулбарыг нь НҮБХХ-ийн суурин төлөөлөгчийн газар болон холбогдох байгууллагуудад хүргүүлж саналыг нь авна
2. Төслийн хүрээнд худалдан авсан бүх тоног төхөөрөмж, техник хэрэгслийг биет эд хөрөнгийн бүртгэлийн дагуу эцсийн байдлаар тоолж, тоног төхөөрөмж тус бүрийн шинж байдал, байршилтай нь хамт бүртгэнэ, эдгээр тоног төхөөрөмж, техник хэрэгслийг ямар байдлаар шилжүүлэх талаар НҮБХХ болон холбогдох байгууллагуудтай хэлэлцэж шийдэл гаргана, гаргасан шийдвэрийн дагуу төслийн холбогдох талуудтай зөвшилцсөний үндсэн дээр тоног төхөөрөмж шилжүүлэх ажлыг хариуцан хэрэгжүүлнэ
3. Төслийн үйл ажиллагаа албан ёсоор хаагдахаас өмнө төслийн ажиллах хүчинтэй холбоотой асуудлуудыг эцсийн байдлаар шийдэж дууссан байна

Ажил хариуцах байдал

Төслийн үндэсний зохицуулагч нь Төслийн үндэсний захирлын ерөнхий удирдлага дор ажиллаж, түүнд ажлаа тайлагнана. Хариуцсан үүргийнхээ хувьд төслийн үндэсний зохицуулагч нь НҮБХХ-т ажлаа хариуцна.

Төслийн үндэсний зохицуулагч нь НҮБХХ-ийн Үндэсний хэмжээнд төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасан дүрэм, журам болон бусад төслийн менежментийн заавар, удирдамжийн дагуу ажил үүргээ гүйцэтгэх ба үүнд төслийн хандивлагчидтай хийсэн гэрээний заалтууд бас хамаарна. Үндэсний төслийн зохицуулагч нь төслийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрх бүхий ажилтан байх ба албан үүргээ гүйцэтгэх явцад хийсэн үйлдэл, явуулсан үйл ажиллагаандаа хариуцлага хүлээнэ. Төслийн үндэсний зохицуулагчийн явуулсан үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй санхүүгийн дүрэм журам, зохицуулалтыг зөрчсөн бол үүний хариуцлагыг биечлэн хүлээж, мөнгөн хохирлыг барагдуулна.

Ерөнхий чадвар

Боловсрол: Магистр ба түүнээс дээш зэрэгтэй (холбогдох чиглэлээр дүүргэсэн бол давуу тал гэж үзнэ)

Туршлага: Холбогдох салбарт дор хаяж 5 жил ажилласан туршлагатай Удирдан, зохион байгуулах ажил эрхэлж байсан

Ур чадвар: НҮБХХ болон бусад хандивлагч байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай бол давуу тал гэж үзнэ
Задлан шинжлэх, үр дүнтэй харилцах чадвартай, компьютерын программуудыг сайн эзэмшсэн

Хэл: Англи ба Монгол хэлээр чөлөөтэй